



МОНГОЛ ХААДЫН ЗАХИДАЛ ДАХЬ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ (ЭЗЭНТ ГҮРНИЙ ҮЕ)

SOME LEGAL ISSUES IN THE LETTERS OF MONGOLIAN KHANS (IMPERIAL PERIOD)

Данзангийн Лүндээжанцан¹

Shihihutug University, E-mail: lundeejantsan@shihihutug.edu.mn, <https://orcid.org/0009-0005-4588-9725>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

гадаад худалдаа, гадаад бодлого, чөлөөт худалдааны үзэл, дипломат ёс горим, алтан аргамж, Их засаг хууль, гуравдагч хөршийн бодлого.

Keywords:

foreign trade, foreign policy, the idea (or principle) of free trade, diplomatic protocol, Golden Tether policy, The Great Yassa, Third Neighbor Policy

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 9 сар
Шинэчилсэн: 2025, 10 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Sep, 2025
Revised Oct, 2025
Accepted Oct, 2025

ХУРААНГУЙ

The article briefly explains the meaning and significance of the concept of the “Golden Tether policy” (Altan Argamj), defining the historical period, geographical context, and underlying reasons for the emergence of this formulation. The authors note that, in its narrow sense, the concept of “Golden Tether policy” originated as a symbol of diplomatic relations and external trade among the nomadic peoples, while in its broader sense, it represents the Mongols’ policy of maintaining friendly and mutually beneficial trade and relations with neighboring and other countries, aimed at ensuring peace and creating a favorable external environment for the nation’s security and prosperity.

The article emphasizes that the “Golden Tether policy” and practice of the Mongolian state were governed by a detailed legal and regulatory framework.

The authors highlight that the nomadic Mongols played a major role in spreading the idea of free trade throughout the world, contributing to the creation and security of the Silk Road that connected the East and the West, and establishing diplomatic norms and practices that significantly influenced the development of human civilization.

The “Golden Tether policy” has thus become a core value and historical tradition of Mongolian foreign policy, which continues to be reflected today in Mongolia’s modern foreign policy principles—such as the pursuit of peace, non-alignment, and the “Third Neighbor” policy.

Өгүүлэлд “Алтан аргамж” хэмээх ойлголтын утга учрыг товч гаргаад уг томъёолол үүсэн гарсан түүхэн цаг үе, орон зай, учир шалтгааныг тодорхойлсон болно. Зохиогчид “алтан аргамж” хэмээх ойлголт нь нарийн утгаараа “элчин харилцаа” болон нүүдэлчдийн гадаад худалдааны бэлгэдэл болж үүссэн бөгөөд өргөн утгаараа монголчуудын төр улсын хөрш болон бусад улс оронтой харилцан ашигтай худалдаа арилжаа эрхлэн найрсаг аж төрөх, улс орныхоо энх амгалан оршихуйн гадаад таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн бодлогоо томъёолж ирсэн ойлголт болохыг гаргасан болно. Өгүүлэлд Монголын төр улсын алтан аргамжийн бодлого, үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн нарийн зохицуулалттай

¹ Шихихутуг их сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга, доктор Sc.D, профессор

байсныг онцлон авч үзсэн болно.

Зохиогчид нүүдэлчин монголчууд дэлхий дахинд чөлөөт худалдааны үзэл санааг түгээж Өрнө, Дорныг холбосон торгоны замыг бүтээлцэн, аюулгүй байдлыг нь ханган, олон улсын харилцааны дипломат ёс горимыг цогцлоолцон хүн төрөлхтний соёл иргэнийлд оруулсан ихээхэн хувь нэмэртэйг дурдсан болно. Алтан аргамжийн бодлого нь монгол төрийн гадаад бодлогын үнэт зүйл, түүхэн уламжлал болж ирсэн бөгөөд эдүгээ Монгол Улсын гадаад бодлогод энхийг эрхэмлэгч, эвсэлд үл нэгдэх болон “Гуравдагч хөршийн бодлого”-д шингэн хэрэгжиж байгаа болно.

Энэ өгүүлэл [CC BY-NC](#) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Монголын ард түмэн олон зууны туршид төв Азийн тал нутагт эрс тэс уур амьсгалтай байгалийн нөхцөлд сонгодог мал аж ахуйгаа эрхлэн аж төрөхдөө орчин ахуйгаа тусгасан ертөнцийг үзэх үзэл болох нийгэм, төр, хууль цааз (эрх зүй), ёс суртахуун, шашны үзэл бодлыг үүсгэн хөгжүүлж иржээ. Монголын түүх өвөрмөц, дахин давтагдашгүй өнгө төрхтэйгөөр бүтээгдэн хүн төрөлхтний оюуны эрдэнэсийн санд оруулсан хувь нэмэр нь өндөр болой.

Өрнө Дорныг холбосон торгоны замыг түвшитгэн арилжаа наймаа, аялал, зорчин явагсдын аюулгүй байдлыг ханган бэхжүүлж, олон улсын харилцааны шударга ёсны үндсийг тавьж, дипломат ёсыг тогтоон бэхжүүлэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ.

Монголын төр ёс, гүн ухаан, хууль цаазын сэтгэлгээний түүх, түүний эх сурвалж нь монголын дагшин түүхийн дээж хэсэг нь бөгөөд оюуны давтагдашгүй арвин сан хөмрөг, монголын ард түмний оюуны үнэт зүйл юм. Монголын түүхийн эх сурвалжийг дотор нь эд өлгийн, аман, бичгийн хэмээн хуваадаг байна.

Бичгийн эх сурвалжид монгол болон бусад хэлээр буй төр улсын бодлогын баримт бичиг, хааны зарлиг, хууль тогтоомж, түүх шастир, бичиг захидал, жуулчдын тэмдэглэл зэрэг ордог бол эд өлгийн зүйлд түүхийн дурсгалт биет зүйлс: барилга архитектур, хөшөө дурсгал, цэргийн зэр зэвсэг, хувцас хэрэгсэл зэрэг зүйлийг хамааруулдаг бол аман сурвалжид аман түүх, түүхэн домог, дурсамж дуртгал, хууч яриаг хамааруулна.

2. Арга зүй

Энэхүү судалгаанд Монголын ард түмний олон зууны нийгэм, төр, хууль эрх зүй, ёс суртахуун, шашны үзэл бодлыг баримтлан, өгөгдлийг бичгийн эх сурвалж (төрийн баримт бичиг, хууль тогтоомж, түүх шастир, жуулчдын тэмдэглэл), эд өлгийн зүйлс (барилга, хөшөө, зэр зэвсэг, хувцас хэрэгсэл), аман эх сурвалж (аман түүх, домог, дурсамж, хууч яриа)-аас цуглуулж, шинжлэх арга зүйгээр дүн шинжилгээ хийх замаар орон зай, цаг хугацааны хувьд харьцуулан судлах аргыг түлхүү ашигласан болно.

3. Судалгааны үр дүн

1. Хаадын захидал судлал

Хаадын захидал судлал нь түүхийн эх сурвалж судлалын эхэнд бичигдэх хэсэг мөн өнөөдрийг хүртэл бие даан судлагдаагүй байна. Энэ судлалын үндсэн эх сурвалж нь хаадын захидал бөгөөд Монголын хаадын (эзэнт гүрний үеийн) захидлын мэдээ баримтыг судлаачдын бүтээлд тусгагдсанаар болон түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэгдсэнээр түүвэрлэн тоймлох байдлаар судалгаа хийгдэж байна. Цаашид захидлын үндсэн уг сурвалжид тулгуурласан судалгаа шинжилгээний эрэлт хэрэгцээ чухал байх тул захидлын хадгалагдсан байдлыг мөшгөн хайх, захидлын сан бүрдүүлэн түүхийн судалгааны эргэлтэд чөлөөтэй оруулах зэрэг судалгаа шинжилгээний шат дараалсан ажлууд чухал байна.

Хаадын захидал харилцааны төрлийн хувьд эзэнт гүрний үед мэдээлэл олж авах, солилцох хийгээд улс орны хэмжээний бодлого, шийдвэрийг илэрхийлэх олон хэв шинж түүхийн судалгааны баримтуудад дурдагдсан байна. Тодорхой нөхцөл байдлын талаар элч илгээн аман мэдээлэл дамжуулахаас гадна, албан ёсны байр суурийг амаар болон бичиг хэлбэрээр илэрхийлэн элч илгээх зэргээр харилцаа холбооны тухайн цаг үеийн боломжит хэлбэрүүдийг ашиглаж байв.

Харилцан холбогдох арга, хэлбэр, дамжуулагдаж буй мэдээллийн утга чанараас хамааран захидал харилцааны хэд хэдэн төрөл байгааг тодорхойлж болох юм.

Тодорхой баримт, мэдээллийг хэнээр буюу ямар эрх хэмжээний элч, төлөөлөгчөөр дамжуулж байгаагаас хамааран агуулгын ялгааг гаргаж болохоос гадна тухайн баримт, мэдээллийг ямар эрх хэмжээний хүнээс илгээж байгаагаар нь ялган зааглах асуудал нэлээдгүй үндэслэл, судалгаа бүхий байна. Тухайлбал, нэрт эрдэмтэн Б.Сумъяабаатар, *Монголын Гадаад харилцааны Бичгүүд тухайлсан нэр томъёотой. Эрдэм шинжилгээний бүтээлд сайтар ялган оноох учиртай. Түшмэл түшээд, жанжид, энгийн хүнийхийг “захиа”, “захидал” гэнэ. Хаан хүнийг “Жуу” (жууу биш), “Жуубичиг” (жууу бичиг биш), “Зарлиг”, мөн “Бичиг”, “Сургааль”, “Өргөмжлөл”, “Айлдвар” хэмээдэг. Агуулгаасаа болоод “Зарлиг” олон янз. “Сургах Зарлиг”, “Тархаах Зарлиг”, “Ухуулах Зарлиг”, “Хэлтрүүлэх Зарлиг”, “Илбэх зарлиг”, “Ял асуух Зарлиг” гэх мэтээр олон төрлүүдийг сурвалж судлалаас ялган авч үзэх шаардлагатайг өгүүлдэг. /Б.Сумъяабаатар аругайтай хийсэн ярилцлагаас/*

Захидал нь албан захидал болон хувийн захидлын² хэлбэртэй байдгаас албан харилцааны зорилгоор хэрэглэгдэх албан захидал нь хаадын гадаад бодлогын хүрээнд хэрэглэгдэх харилцаа холбооны үндсэн хэлбэр байв. Эзэнт гүрний дотоодод буюу хаад хооронд бичигдсэн захидлын талаарх баримт мэдээлэл сурвалж бичиг, судалгааны бүтээлүүдэд арвин бий. Энэ илтгэлийн агуулга нь Монгол хаадаас бусад улс орны хаад, шашны зүтгэлтэн зэрэг эрх мэдэлтэнд илгээсэн албан захидлын баримт мэдээллийг хүргэхийг зорьсон болно.

² “Захидал” гэдэг нь албан газар буюу хүмүүсийн хоорондын харилцааны захиа: албан захидал, хувийн захидал. Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 271., Монгол хэлний тайлбар толь. Уб., 2018. 591.

2. Хаадын захидлын товчоон

№	Захидал	Агуулга	Огноо/захидал бичсэн газар	Эх сурвалж
1. Их Монгол улс				
1.1. Их эзэн богд Чингис хаан (1206-1227)				
1.1.1.	Их эзэн богд Чингис хаанаас Хорезмшагид илгээсэн захидал 1, 2	Захидал-1: Хорезмтай худалдаа хийх, торгоны замын аюулгүй байдлыг хангах. Захидал-2: Хорезмшагаас худалдаачдыг хөнөөсөн этгээдийг хүлээлгэн өгөхийг шаардсан агуулгатай.	1215-1218 үед	Рашидаддины “Шаширирын чуулган”-д ишлэгдсэнээр
1.1.2.	Их эзэн богд Чингис хаанаас Корйө улсад илгээсэн захидал-1	Корйөг дагаар орсныг сайшаасан тухай агуулгатай.	1218	Судалгааны бүтээлд ишлэгдсэнээр
1.1.3.	Их эзэн богд Чингис хаанаас Корйө улсад илгээсэн жуубичиг	Их Монгол Улсад Корйө улсад дагаар оронд нь талархал илэрхийлж, их хэмжээний бэлэг хүртээсэн тухай агуулгатай.	1219	Судалгааны бүтээлд ишлэгдсэнээр
1.1.4.	Их эзэн богд Чингис хаанаас Корйө улсад илгээсэн захидал	Корйө улсаас халиуны арьс нэгэн түмэн лин, нарин торгомсог гурван мянган толгой, мяндас түмэн жин, лунтуан бэх мянган нийлүүр, бийр хоёр зуун гуурс, цаас арван түмэн хуудас, бэрээмэг таван жин, гүргүм, будуг шунх тус бүр тавин жин, шаруца, шир, тос тус бүр арван жин нэхсэн тухай агуулгатай.	1221	Судалгааны бүтээлд ишлэгдсэнээр
1.1.5.	Их эзэн богд Чингис хаанаас Чанчун Бомбод хүргүүлсэн заллагын захидал	Их эзэн богд Чингис хааны үзэл бодол, үйл хэргийн тухай өгүүлсэн буюу өөрийн амьдралын хэв маяг, Алтан улсын эзлэгдсэн шалтгаан нөхцлийн тухай өгүүлээд, Чанчунь бомбыг залж ирүүлэн сургаал номлолыг сонсох, зөвлөгөө авах тухай утга агуулгатай.	1219.V.15	Өнөөдөр уг захидлын эх байхгүй ч түүнээс шууд хуулбарлан чулуун дээр сийлэн бичсэн хувь хадгалагдаж ирсний дээр, Бээжин хотын Байюньгуань хэмээх Чанчунь бомбын сүм зэрэг газарт түүнээс авсан хувь хуулбар, мөн уг захидлын дундад зууны үеийн худам монгол орчуулга зэрэг баримт бичиг байдаг байна. 1309 онд Хэнань мужийн Нэйсян хошууны Шитаншань хэмээх ууланд агч Пузигун хэмээх сүмийнхэн Чингис хааны алдар сууг мөнхөлж, Чанчунь бомбын байгуулсан

				<p>гавьяаг алдаршуулах зорилгоор Дэнжоу нутгийн чулуучин Ли Зинжун гэгчээр чулуун дээр сийлүүлж үлдээжээ. Тухайн үед зарлигийн захидлыг олируулан хувилж, Бомбын шашны сүм хийдүүдэд тараан түгээж байж гэж үздэг байна. Уг хөшөө чулуу нь 1.8 м өндөр, 63 см өргөн, 23 см зузаантай агаад хятад ханз үсгийн хичээнгүй бичгийн тигээр сийлэн бичсэн, нийт 16 мөр, нэг мөрөндөө 32 ханз үсэгтэй ажээ.³</p>
1.2. Их хаан Өгэдэй (1229-1241)				
1.2.1.	Өгэдэй хаанаас Корйө улсад хүргүүлсэн жуубичиг	Их хаан Корйө улсад цэргээр туслан тэднийг хятан нараас чөлөөлсөн тухай онцлоод, хааны элч Хуарилнйө-д захирагдаагүй, элч Куагойө-ийг хороосон зэрэг хэргийг байцаалгахаар илгээсэн элчисийг харваж буцаасанд ял асууж, элчийг хороосон хүнийг гаргаж өгөхийг шаардсан агуулгатай.	1231	Жуубичгийн эх хувь тодорхойгүй ба албан ёсны сурвалж бичигт дурдагдсан ⁴
1.3. Их хаан Гүюг (1246-1248)				
1.3.1.	Ромын пап IV Инноцентээс Гүюг хаанд ирүүлсэн захидал	Ромын пап IV Инноцент нь их хааныг европын орнуудыг дайлахаа болихыг тэнгэр бүрхны нэрийг барьж, сануулан гуйсан байдаг. Улмаар, монголчуудыг найрамдаж, хойшид хэрхэхээ дуулгахыг хүссэн утгатай.	1245	Латин хэлээр, 2 хуудас, цаасан дээр хар бэхээр, өндөр 36 см, өргөн 24 см Ватиканы нууц архив, бүртгэлийн дугаар Vat., 21, ff. 107 v. – 108 r. ⁵ Зарим эх сурвалжид Ватиканы нууц архивт ASV, Reg.Vat.21, fol.208r дугаартай хадгалагддаг гэсэн байна.
1.3.2.	Гүюг хаанаас Ромын пап IV Инноцентэд бичсэн захидал ⁶	Захидлын эхний мөрөнд “Мөнх тэнгэрийн хүчинд далай их хаан бидний зарлиг хэмээн түрэгээр бичээд, персээр үргэлжлүүлсэн байдаг. Эл хоёр хэлээр мөртөө араб үсгээр бичсэн ажээ. Пап ламыг наран жаргах	1246	Цаасан дээр хар бэхээр, өндөр 16,5 см, өргөн 97 см, Ватиканы нууц архив, бүртгэлийн дугаар А.А., Art I – XVIII, 1802 (2), 1246.11.11 Гүюг хаан Хархоринд найруулан бичсэн харцу захидлыг

³ www.sonin.mn “Чингис хаан Чанчунь бомботой уулзсаны түүхт ой” нийтлэл, Я.Ганбаатар, 2018.10.19, <https://sonin.mn/news/culture/96285>, үзсэн: 2022.09.10

⁴ Ledyard, G. (1963). Two Mongol Documents from the Koryō sa. *Journal of the American Oriental Society*, 83(2), 225–239. <https://doi.org/10.2307/598366>

⁵ Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн үзэсгэлэнгийн каталог монгол хэл дээр, ХБНГУ, 2010, 249.

⁶ Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. 2010, 249

		зүгийн улсын тэргүүнүүдийг дагуулан хүрэлцэн иртүгэй гэжээ. Пано де Карпинигаар, шашинд нь орох тухай амаар хэлүүлсэн үгийг огт тоосонгүй, Европ зүгийн орнуудыг дайлах болсон тухайгаа Гүюг хаан бээр, түүний элчийг христүүд буюу оросын тайж нар алсан явдлыг үндэс болгожээ. Захидлынхаа төгсгөлд: Та нар зарлигийг эс дагавал юу болохыг бид бус, тэнгэр мэдтүгэй хэмээсэн байна.		ромын пап ламын элч төлөөлөгчөөр латинаар нямбай орчуулуулж авсан байна. Монголчууд элч нарт уг нь захидлын эхийг болон Европ дахинаа монгол хэлнээс арай илүү танигдсанаар нь перс хэлээр орчуулсныг өгч явуулах гэсэн байдаг. Перс эх нь латин эхээсээ арай дэлгэрэнгүй ажээ.
1.4. Их хаан Мөнх (1251-1259)				
1.4.1.	Мөнх хаанаас Францын хаан IX Гэгээн Лүид хүргүүлсэн захидал	Дэлхий дахиныг нэг улс болгох санаа зоригийг илэрхийлсэн, Франкуудтай дипломат харилцаа тогтоох утга агуулгатай байна.	1254	Гийом де Рубрукийн “Монголын эзэнт гүрэнд зорчсон нь” тэмдэглэлд дурдагддаг ⁷
1.4.2.	Мөнх хаанаас Корйө улсын ванд илгээсэн жуубичиг	Корйө улсын ванг өмнө нь хэлсэн амандаа хүрэхгүй байна гэж буруутган зэмлээд, бүрэн хүчээ өгч дагахыг чиглэл болгож буй утга агуулгатай.	1259	Түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн ⁸
2. Их Монгол хэмээх Их Юань улс				
2.1. Хубилай хаан (1260-1294)				
2.1.1	Хубилай хаанаас Корйө улсад хүргүүлсэн захидал	Их хаан өөрийн төр барих арга ухаан, үзэл баримтлалаа дурдаад, бослого гаргасан сайд, түшмэдийг шийтгэх, Корйөгийн засаг захиргаа, эдийн засгийг илбэн товхинуулах тухай захирамжилсан агуулгатай.	1260	Түүхэн сурвалжид тэмдэглэгдсэн ⁹
2.1.2	Хубилай хаанаас Японы хаанд (шоогун) илгээсэн захидал	Их хаан өөрийн барьж буй дипломат бодлого, үйл ажиллагааны тухай өгүүлээд, дагаар ороогүй нөхцөл зэвсгийн хүч ашиглахаар сүрдүүлсэн утгатай.	1266.VIII	1268 онд үйлдсэн хуулбар, “Дайсагнасан улс орнуудыг бурхны шашины буянаар дийлсэн тухай тэмдэглэлүүд” хэмээх номын хоёр хуудас, цаасан дээр бэхээр, 25,5 x 39,4 см Японы Нара дахь Тодай-жи сүм ¹⁰
2.1.3	Хубилай хаанаас Ромын пап ламд хүргүүлсэн захидал	Их хаан өөрийн шашины үзэл баримтлалын тухай өгүүлсэн агуулгатай.	1264-1269 үед	Судалгааны бүтээлд ишлэсэнээр ¹¹
2.1.4	Ромын пап IV Николасаас	Католик шашинд орохыг ятгасан утгатай.	1289.VII. 13. Риети	Ромын папын элч Жованни

⁷ Гийом де Рубрук “Монголын эзэнт гүрэнд зорчсон нь” тэмдэглэл, Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг, Уб.,2010.106.

⁸ Гуулин улсын судар. 25-р дэвтэр. 2-3.

⁹ Гуулин улсын судар. 25-р дэвтэр. 10-13.

¹⁰ Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. 2010, 333.

¹¹ Марко Пологийн жуулчлалын тэмдэглэл, Өвөр монгол хэвлэл, Хөх хот, 1978

	Хубилайд хүргүүлсэн захидал		хот	Монтекорвиногийн аялалын тэмдэглэл дурдагддаг ¹²
2.1.5	Хубилай хаанаас Ромын пап Грегорид хүргүүлсэн захидал	Их хаан Ромын папаас мөнх зулын тос, католик шашин номлогч 400 лам ирүүлэхийг хүссэн.	1292	Судалгааны бүтээлд ишлэсэнээр ¹³
3. Зүчийн/Алтан ордны улс				
3.1.	Алтан ордны хаан Батаас Унгарын хаан IV Белад хүргүүлсэн захидал	Энэ захидалдаа хаан Белад Кумануудыг Унгарын нутгаас хөөн гаргаж, Монголын цэрэгт бууж өгөхийг шаардсан байна.	1237-1238 үед	Ватиканы нууц архивын гар бичмэлийн фондод лам Юлианусын тэмдэглэл байсныг 1695 онд Унгарын Есуйт урсгалын Челеш Мартон гэдэг лам олсон байна.
3.2.	Алтан ордны хаан Тохтамышаас Польшийн хаан, Литвийн их ван Валдислав II Ягеллод хүргүүлсэн захидал	Польшийн хааны мэдэлд байх тодорхойгүй газар нутгийг хамтран эзэмших, энхийн гэрээ байгуулах асуудлыг хөндсөн агуулгатай.	1393	20,5 x 42 см хэмжээтэй 2 хуудас муутуу цаасан дээр бичигдсэн, Варшав, бүртгэлийн дугаар 5612, Эртний баримт бичгийн ерөнхий архив
4. Цагадайн улс				
4.1.	Ромын пап IV Николасаас Цагадайн улсын төрийг de facto барьж байсан Хайду ханд илгээсэн захидал	Цагадайн улсад Христийн шашныг түгээн дэлгэрүүлэх, бэхжүүлэх асуудлыг хөндсөн агуулгатай.	1289.VII.13	Судалгааны бүтээлд ишлэгдсэн ¹⁴
4.2.	Ромын пап XXII Жонноос Цагадай хаан Элжигдэйд илгээсэн захидал	Мөн адил утга агуулгатай үгстэй.	1329.XI.02	Судалгааны бүтээлд ишлэгдсэн
4.3.	Ромын пап XII Бенедиктээс Цагадай хаан Женкишид илгээсэн захидал	Цагадай хаан Женкишигийн бичсэн захидлын хариу захидал гэж дүгнэдэг. Мөн адил утга агуулгатай үгстэй.	1338.VI.13	Судалгааны бүтээлд ишлэгдсэн
5. Ил хаант улс				
5.1. Ил хаан Хүлэгү (1256-1265)				
5.1.1	Ил хаан Хүлэгүгээс Ираны Халиф Мустасимд илгээсэн захидал	Персийг дайлах үед цэргийн тусламж ирүүлэхийг хүсэхэд хариу өгөөгүйг дурьдаад, дагаар орохыг шаардсан агуулгатай.	1257	Судалгааны бүтээлд ишлэгдсэн
5.1.2.	Ил хаан Хүлэгүгээс	Монголчуудын сүр хүчийг илт харуулсан ба Мамлюкийн	1260	Судалгааны бүтээлд ишлэгдсэн

¹² Robson, M. (2006). *The Mission to China. In The Franciscans in the Middle Ages* (pp. 108-118). Boydell & Brewer.

¹³ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. Тэргүүн боть. Нэн эртнээс XVII зуун. Ред. Нацагдорж Ш., Уб., 1966, 298.

¹⁴ BIRAN, M. (2008). *Diplomacy and chancellery practices in the chagataid khanate: some preliminary remarks. Oriente Moderno*, 88(2), 369–393. <http://www.jstor.org/stable/25818180>

	Мамлюкийн Кутузд илгээсэн захидал	султан тэдний эсрэг өчүүхэн болохыг тодруулсан утгатай.		
5.1.3.	Ил хаан Хүлэгүгээс Францын хаан IX Луид илгээсэн захидал	Египет болон Сирийн эрэг хавийн франкуудын хүчийг зузаатгаж нийтлэг дайснаа дарахыг уриалсан агуулгатай.	1262	Судалгааны бүтээлд ишлэгдсэн ¹⁵
5.1.4.	Ил хаан Хүлэгүгээс Ромын пап IV Урбанд илгээсэн захидал	Францын хаан IX Луид илгээсэн захидалтай ижил агуулгатай.	1262	Судалгааны бүтээлд ишлэгдсэн
5.1.5.	Ромын пап IV Урбанаас Ил хаан Хүлэгүд илгээсэн захидал	<i>Exultavit cor nostrum</i> буюу Бидний сэтгэлийн баясал: Христ шашныг даган адислуулах хүсэлтэй байгаад талархана, адис авсны дараагаар буруу номтныг дарахад тусална гэсэн агуулгатай.	1263.V.23	Ватиканы нууц архивд ASV, Reg.Vat.29-V, fol.6r-7r дугаартай хадгалагдаж байна.
5.2. Ил хаан Абага (1265-1282)				
5.2.1.	Ил хаан Абагаас Мамлюкийн султан Байбарст илгээсэн захидал	Монголчуудын Айн Жалутад болсон ялагдал алтан ургийнхны дотор эв нэгдэл алдагдсанаас болсныг тайлбарлаад одоогоор ахан дүүс Чингис хийгээд Их хаан Хубилай хаадын зарлиг болон Их засаг хуулийг хэрэгжүүлэхээр санал нэгдсэн гэсэн агуулгатай.	1268.XII	Судалгааны бүтээлд ишлэгдсэн ¹⁶
5.2.2.	Ил хаан Абагаас Ромын пап IV Клеменцэд илгээсэн захидал	Монгол, франкуудын хооронд эвсэл байгуулан мамлюкуудыг довтлох санал дэвшүүлжээ.	1267-68 үед	Латин хэлээр, Ватиканы нууц архивт ASV, Reg.Vat.62, fol.138v-139r дугаартай хадгалагдаж байна.
5.2.3.	Ил хаан Абагаас Ромын пап X Грегорид хургүүлсэн захидал	Ил хаан Хүлэгүгийн явуулж байсан бодлого, монголчуудын Айн Жалутад ялагдсан шалтгааныг тайлбарласан агуулгатай.	1274	Судалгааны бүтээлд ишлэгдсэн
5.2.4.	Ромын пап III Николасаас Ил хаан Абагаас ирүүлсэн захидал	Ил хаан Абагаас Ромын пап X Грегорид 1274 онд хургүүлсэн захидлын харуу.	1278.IV.01	Ватиканы нууц архивт ASV, Reg.Vat.39, fol.71r-72r дугаартай хадгалагдаж байна.
5.2.5.	Ил хаан Абагаас Ромын католик шашны элчид олгосон аян замын баталгаа үнэмлэх бичиг	Ромын пап III Николасаас Илхаан Абага руу илгээсэн таван санваартан Монголын нутагт хүрч буцахад нь дайран өнгөрөх нутгуудын эзэн Самагар зэрэг ноёдод хандан монгол бичгээр үйлдэн олгосон	1279	Үнэмлэх бичгийн эх хувь Ватиканы нууц архивт хадгалагддаг, бүртгэлийн дугаар A.A. Arm. I-XVIII, 1801 (1)

¹⁵ The Mongols and the West. Peter Jackson. 2014.166.

¹⁶ Amitai-Preiss, R. (1994). An Exchange of Letters in Arabic between Abaya Ilkhān and Sultan Baybars (A. H. 667/A. D. 1268-69). *Central Asiatic Journal*, 38(1), 11–33. <http://www.jstor.org/stable/41929455>

		туулай жилийн аян замын баталгаа үнэмлэх бичиг юм.		
5.3. Ил хаан Ахмад Тэгүдэр/ Төгөлдөр (1282-1284)				
5.3.1.	Ил хаан Ахмад Тэгүдэрээс Мамлюкийн султан Калаунд хүргүүлсэн захидал-1	Исламын хоёр улсын төрийн тэргүүнүүдийн хооронд найрамдалт харилцаа тогтоохыг эрмэлзэж буйгаа илтгээд, өөрийн явуулж буй шашины бодлого, худалдаачдын аюулгүй байдлыг хангах, харилцан нэг нэгнээ тагнах явдлыг зогсоох, өөрийн зүгээс Чингисийн алтан ургийнхны мамлюкуудын эсрэг явуулж буй тэмцлийг зогсоох зэрэг асуудлуудыг захидалдаа бичжээ.	1282.VIII	Судалгааны ишлэгдсэн ¹⁷ бүтээлд
5.3.2.	Мамлюкийн султан Калаунаас Ил хаан Ахмад Тэгүдэрт хүргүүлсэн захидал	Тэрээр Ил хааныг исламын шашинд орсныг таашаагаад, гийчид болон мөргөлчдийг хамгаалалтдаа авахыг зөвшөөрсөн байна. Мөн түүнчлэн мусульман биш байсан Хүлэгү хаан эцгээ яахин гүйцэх вэ гэж Ахмадыг чамласан байна.	1282.XII.03	Судалгааны ишлэгдсэн ¹⁸ бүтээлд
5.3.3.	Ил хаан Ахмад Тэгүдэрээс Мамлюкийн султан Калаунд хүргүүлсэн захидал-2	Алтан орд болон Ил хаант улсын Холбоонд Египетийн мамлюкуудыг оруулж, гурамсан холбоо байгуулах саналыг дэвшүүлжээ.	1283.V-VI	Судалгааны ишлэгдсэн ¹⁹ бүтээлд
5.4. Ил хаан Аргун (1284-1291)				
5.4.1.	Ромын пап IV Николасаас Ил хаан Аргунд ирүүлсэн захидал	Захидлын агуулга тодорхойгүй.	1288. IV. 2.	Ватиканы нууц архивд ASV, Reg.Vat.44, fol.313r-314r дугаартай хадагалагдаж байна.
5.4.2.	Ил хаан Аргунаас Францын хаан Гоо Филиппэд илгээсэн захидал	Египет дэх мамлюкуудын эсрэг Европын нөлөө бүхий удирдагчидтай хамтран холбоо байгуулж, 1292 оны II сард Филипп хаан Дамаск хотод өөрийн цэргийн хамт бэлэн байж хамтарсан тулаан эхлүүлэх саналыг захидалдаа дэвшүүлсэн.	1289	Солонгос цаасан дээр хар бэхээр монгол бичгээр бичсэн. 182x25 см хэмжээтэй. Францын үндэсний архив, Парис бүртгэлийн дугаар АЕ/III/202 ²⁰
5.4.3.	Ил хаан Аргунаас Ромын пап IV Николаст хүргүүлсэн харуу захидал	Христийн шашинтай эртнээс холбоотой гэдгээ дурдаад, харин ч өөрсдийнхөө Мөнх тэнгэрийн адил үнэн зөв хэмээн мэдэгдсэн байна. Түүнчлэн Мөнх тэнгэрийн болоод	1290. V.14	Энэхүү захидал нь бүрэн бус, Ватиканы нууц архив, бүртгэлийн дугаар А.А. Арт. I-XVIII, 1801 (3)

¹⁷ Баярсайхан Д. Хүлэгү хаанаас Абу Са'ид хүртэл: Ил Хаадын тухай өгүүлүүд. 2016., 91.

¹⁸ Баярсайхан Д. 2016., 92.

¹⁹ Баярсайхан Д. 2016. 92-95.

²⁰ Францын үндэсний архив. Парис. https://www.siv.archives nationales.culture.gouv.fr/siv/UD/Fran_IR_055193/A1_136

		христийн шашинт иргэн зөв амьдарч байгаа, бусад нь харин мууг үйлдэх нь илүү гэсэн харьцуулалтыг оруулсан. Ингээд Чингис хааны ургууд адис хүртэх эсэхийг Мөнх тэнгэр л мэднэ гэжээ.		
5.5. Ил хаан Газар/Хайсан/ (1295-1304)				
5.5.1	Ил хаан Газанаас Ромын пап VIII Бонифаст илгээсэн захидал	Египет дэх мамлюкуудын эсрэг хамтран холбоо байгуулахыг уриалсан агуулгатай.	1302.IV.12	Захидлыг уйгаржин монгол бичгээр бичсэн. Бэхээр пергамент дээр бичсэн, 24x97 см Ватиканы нууц архив, Ватикан, бүртгэлийн дугаар А. А., Arm. I-XVIII, 1803 (3)
5.6. Ил хаан Өлзийт (1304-1316)				
5.6.1	Ил хаан Өлзийтөөс Францын хаан Гоо Филиппт илгээсэн захидал	Чингис хааны үр сад эргэн санаа нэгдсэн тухай өгүүлж, урьд Европчуудтай сайн харилцаатай байсныг дурдаад, дахин элч илгээн бэлэг солилцох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Мөн тэрээр улс орнууд, ард түмнүүд хоорондоо эв нэгдэлтэй байхын чухлыг захидалдаа онцолжээ. ²¹	1305. VI	Захидлыг Пап лам, Франц болон Английн хаадад зориулан бичсэн гэж үздэг ба захидлын ар талд Латин орчуулгыг хаджээ. Захидал 300x51 см цаасан дээр хар бэхээр бичсэн, Францын үндэсний архив, Парис, бүртгэлийн дугаар АЕ/III/203. ²²

Монгол хаадын захидлуудад хийсэн эрх зүйн шинжилгээ

Монгол хаадын захидалд эрх зүйн шинжилгээ хийх нь түүхийн болон эрх зүйн судлал хосолсон эрх зүйн судалгааны онцлог хэсэг юм. Түүхийн бичлэгийн зарчмуудад байх нэг чухал зарчим нь, *нийгмийн дэвшлийн буюу ирээдүйг баримжаалах зарчим*²³ юм. Энэ зарчмаар, “түүх бичлэгээр дамжуулан үндэсний үзэл санааг гаргадаг”, “түүх бичлэг бол үндэсний үзэл санааг төлөвшүүлэн ирээдүйн чиг баримжааг гаргадаг”, “түүхээ арагшаа биш урагшаа харж бичих ёстой” гэсэн утга илэрхийлдэгтэй бүрэн санал нэгдэж байна.

Иймийн учир хаадын захидалд эрх зүйн үүднээс товчхон дүгнэлт өгөхийг оролдон, энэ нь цаашид Монголын эрх зүйн онолын суурь үзэл баримтлалыг хөгжүүлэх ирээдүйн судлаачдад багахан ч атугай хувь нэмэр болно гэдэгт итгэж байна.

2.1. Хаадын захидал дахь эрх мэдлийн асуудал

²¹ Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн үзэсгэлэнгийн каталоги монгол хэл дээр, ХБНГУ, 2010. 312.

²² Францын үндэсний архив. Парис. https://www.siv.archivesnationales.culture.gouv.fr/siv/UD/Fran_IR_055193/A1_137

²³ Ганхуяг Д. Баатархуяг А. Монголын түүх бичлэг ба түүхийн социологийн асуудлууд. Монголын түүх судлал: түүхийн философийн шинэ хандлага, тулгамдсан асуудлууд симпозиумд тавьсан илтгэл. Илтгэлийн хураангуй. Уб., 2014, 143.

Аливаа нэг үзэгдэл, үйл явц, баримт мэдээлэлд эрх зүйн шинжилгээ хийхийн утга нь товчхондоо зүй ёсны дагуу буюу хүлээн зөвшөөрөгдөхүйцээр эрх, эрх мэдлийн хуваарилалтын асуудал хэрхэн хамаарч байгааг тодруулахад оршино.

Эрхийн тухай, эрх мэдлийн тухай философи, эрх зүй судлалын олон онол, үзэл хандлага өрсөлдөн байх хэдий ч эдгээрээс аль нэг тодорхой онолоор дэмжин дүгнэх эсхүл буруушаан үгүйсгэх нь энэ төрлийн судалгааны арга зүйд хэвшмэл болж байна. Харин судлаач судлан шинжлэх асуудлын мөн чанарт илүү тохирох үзэл хандлагыг оновчтой сонгон тайлбарлах ур чадвараар өрсөлддөг болжээ.

Эрх мэдлийн “зүй ёсны буюу нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх” шинж нь түүнийг хууль ёсны болгодог.

Эрх мэдэл бол зүй ёсны ойлголт болох талаар судлаач Морис Дюверже *Улс төрийн байгууламж, Үндсэн хуулийн эрх зүй бүтээлдээ* тусгажээ. Тэрээр, эрх мэдэл нь юуны өмнө зүй ёсны үзэгдэл. Зүй ёсны гэдгийг нэлээд хэдэн янзаар тайлбарлаж болно гээд засаглалын зүй ёсны шинж чанаруудыг нэр хүндийн асуудал, нэр хүндийг хүлээн зөвшөөрөх буюу засаглалын уг сурвалжийн асуудал, засаглалд захирагдах ухамсрын асуудал байдлаар²⁴ тайлбарласан нь нэлээд тал өгүүштэй.

Судлаач Морис Дюверже нэр хүндийн ойлголтыг энгийн утгаар тайлбарласан байх бөгөөд ингэхдээ “зохих хэмжээгээр бусдад тоогдох” чадварын тухай өгүүлж, бөөгийн нэр хүндтэй холбон авч үзэн, “...хэн илүү нэр хүндтэй, бусдад тоогдож чаддаг нь толгойлогч байдаг. Энэхүү ойлголтыг бөөгийн нэр хүндтэй холбож үзэж болно. Зарим овог отгийнхон энэхүү нэр хүндийг аль нэг ид шидтэн, аль нэг толгойлогчдод захирагдах далдын хүч гэж үздэг байна²⁵” гэжээ. Чухам энэ тайлбараар эрх мэдэл олж авах нэр хүнд нь Чингис хаан болон монголын бусад хаад тэнгэрт шүтэх үзлийн илэрхийллийг төрийн хэрэгт ашигладаг²⁶ байсантай холбоотой байж болох юм. Эл утгыг “Занишлын эх сурвалжийн хэв шинж захидлуудад тусгагдсан нь” хэсэгт тодруулан авч үзнэ.

Нэр хүндтэй байх нь эрх мэдлийн анхдагч шинж мөн юм бол тэр нь түүнийг хүлээн зөвшөөрөх этгээдүүдтэй ямар нэгэн холбоотой байх уг сурвалжийн асуудал дараагийн шинж болно. *Иргэн хүн төр засагтаа хандах байдал нь хүүхэд эцэг, эхдээ хандах байдлаас үндэстэй байдаг*²⁷ хэмээн Морис Дюверже үзэн улсын хаан болон Ромын паптай холбосон бол, Чингис хааны “эзэн эрх”-ийн талаарх судалгаандаа, *Чингис хаан насан туршдаа Монгол тугтны төлөө зүтгэж, “Эзэн” хүний үүрэг хариуцлагыг гүйцэтгэсэн болохоор ийнхүү хүндэтгэлийг хүртээж байгаа юм*²⁸ хэмээн судлаач Эрдэмт дүгнэсэн байна.

Энэ талаар судлаач Эрдэмт Чингис хааны “эзэн эрх”-ийн үзлийн тухай өгүүлэх нь нийтлэлдээ Чингис хааны “эзэн эрх” төрөлх чанартай бөгөөд энэ нь хүүхэд ахуйд, гэр бүлийн хүрээнд болон төр улсын хэмжээнд хэрхэн тод томруун харагдаж байсныг

²⁴ Морис Дюверже. *Улс төрийн байгууламж /Үндсэн хуулийн эрх зүй/. Орчуулгын редактор Т.Төмөрхүлэг. Уб., 2007. 30-34.*

²⁵ Морис Дюверже. 2007. 32.

²⁶ Пунсаг А. Чингис хаан хийгээд монголын уламжлалт соёлын зарим суудал. Түүхийн судлал. XXXVII боть. Уб., 2007. 63.

²⁷ Морис Дюверже. 2007. 33.

²⁸ Эрдэмт. Чингис хааны “Эзэн эрх”-ийн үзлийн тухай өгүүлэх нь. Түүхийн судлал XXXVI боть. 45-46.

тайлбарласан байдаг. Дүгнэлттэй холбогдох утга нь, Хорезмшаг болон Чингис хааны хоорондох түүхэн үйл явдалтай холбоотой билээ.

Чингис хаан Бахар гэдэг мусульманаар улсын элч болгож, бусад хоёр монгол хүнийг нь дэд элчээр томилж, Хорезмын султанд илгээж, арилжааны ангийн хэрэг явдлыг мэдүүлэн зүй ёсны шаардлага тавив. Үүнд Хорезмын Султан Чингис хааны төв ёсны шаардлагад хэрцгий балмад омог бардмаар хандаж, үзээд хэрэгссэнгүйгээр барахгүй ирсэн элчийн сахлыг хусаж, улсын газраасаа үлдэн гаргажээ. Эл хэрэг явдалтай холбоотойгоор, *Чингис хаан өөрийн арилжааны ангиа тоногдож, арилжаачид нь алагдсан атал Хорезмын улсын “эзэн эрх”-ийг хүндэтгэж, төв ёсны шаардлага тавьсанд Алладин Махмуд ихэрхэн дээрэлхэж, гутаан доромжилсон тул Чингис хаан “эзэн эрх”-ээ хамгаалах шударга ёсны дайныг хийв...олонх түүхчид Чингис хааны энэхүү дайныг “Түрэмгий дайн” гэдэг бөгөөд үүнээс болж Чингис хааныг “Том түрэмгийлэгч” гэж үнэлэгдсэн. Үнэнийг хэлэхэд, хүн төрөлхтний бусад амьтан араатнаас ялгагдах тодорхой зөрөө гэвэл түүний “хариуцлагад овор” болно. Хүн өөрийн үйл ажиллагаандаа хамгаас их хариуцдаг. Монголчууд өөрийн толгойлогчоо “эзэн хаан” гэдэг Онцгойлон Чингис хааныг “Эзэн Чингис” гэдэг буюу “Богд эзэн Чингис хаан”, “Эзэн богд өвөг Чингис” гэж хүндэтгэн дууддаг билээ. Эгэл Монголчууд яагаад ингэж хүндэтгэдэг билээ гэвэл ганц үг-Чингис хаан насан туршидаа Монгол тугтаны төлөө зүтгэж, “Эзэн” хүний үүрэг хариуцлагыг гүйцэтгэсэн болохоор ийнхүү хүндэтгэлийг хүртээж байгаа юм²⁹ хэмээжээ.*

Чингис хаан болон Монголын эзэнт гүрний бусад хаадын эрх мэдэл нь дээр дурдсанаар тэдний “эзэн эрх”-ээр тодорхойлогдож байсан гэж үзэх үндэстэй.

Эрх мэдэл хууль ёсны байх итгэл үнэмшил нь түүний “бүрэн эрхт байдал”-тай холбоотой ба бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, бүрэн эрхэд захирагдах утгаар илэрнэ.

Судлаач Морис Дюверже хууль ёсны талаарх итгэл үнэмшлийн гол агуулга нь “бүрэн эрхт байдал”, өөрөөр хэлбэл, засаглалын эх үүсэл бөгөөд “дээд эрх баригч” нь эрх мэдлийн угийн цол, засгийн жинхэнэ үүсэл юм гээд бүрэн эрхт байдал болон хууль ёсны олон онол байдгаас “тэнгэрлэг бүрэн эрхт байдал”, “ард түмний бүрэн эрхт байдал” номлолуудад тайлбар хийсэн байдаг.

Түүнийхээр тэнгэрлэг бүрэн эрхт байдлын номлолын хүрээнд, *засаглалын эх үүсэлтэй холбоотой хамгийн эртний итгэл үнэмшил нь “тэнгэрийн бошиг” юм. Үүгээр Бурхан өөрөө эрх баригчдад засаглах эрх өгдөг. Энэ номлол гүнзгий хувьсан өөрчлөгдөж, шат дараа дамжсан гурван хэлбэрийг олжээ. 1. Юуны өмнө эрх баригчид угаас засаглах тэнгэрлэг заяатай гэдэг. Үнэн хэрэгтээ тэднийг Бурхан томилоогүй, учир нь тэд өөрсдөө бурхад болж тэнгэрлэг заяатын тоонд ордог. Түүхийн тодорхой нэгэн үед энэ хэлбэр ихэд дэлгэрсэн байлаа. Египетийн Фараонууд, Ойрхи Дорнодын хаад, Ромын эзэнт гүрний эзэн хаад өөрсдийгөө бурхан хэмээн үзэж байсан. Японы эзэн хаан өөрийгөө 1947 он хүртэл ингэж үзэж байв. 2. Христийн шашин үүссэн цагаас энэхүү номлолд сүрхий өөрчлөлт оржээ. Тэр үеэс эхлэн засаглагчдад бурхнаас олгосон эрхийн талаар ярих болжээ. Эрх баригчдыг Бурхан томилдог, харин тэд өөрсдөө жирийн хүмүүс юм. Бурханы сонголтоор тэдэнд онцгой агуу их эрх дарх олгодог. 3. Дундад зууны*

²⁹ Эрдэмт. Чингис хааны “Эзэн эрх”-ийн үзлийн тухай өгүүлэх нь. Түүхийн судлал XXXVI боть, 45-46.

үес бурхны тэнгэрлэг эрх мэдэл гэдгийг Тэнгэрийн бошиг (зарлиг) хэмээсэн утгаар маш өргөн хэмжээнд хүлээн авах болжээ. Эрх баригчдыг томилоход бурхан шууд оролцдоггүй. Хэрэв бүх эрх сэдэл Бурханаас энд хутгалдаж оролцохгүй. Бурхан тэнгэр өөрийн зарлигаар хүмүүст олгосон эрх чөлөөнийхөө хүрээнээс ер гарахгүй³⁰ гэж тайлбарлажээ.

Монголын их хаадын захидал дахь “мөнх тэнгэрийн хүчин дор”, “тэнгэрийн бошгыг дагах”, “тэнгэр мэднэ”, “тэнгэрт залбирч”, “тэнгэрийн хишгээр”, “мөнх тэнгэрийн тогтоосон зарлиг”, “мөнх тэнгэрээс Чингис хаанд буулгасан бошго сургаалыг”, “тэнгэрийн хүчинд”, “тэнгэрийн соёрхлыг” гэсэн утгууд нь тэнгэрлэг бүрэн эрхт байдлын илэрхийлэл мөн юм.

Хаадын “эзэн эрх”-ийг хүлээн зөвшөөрсний баталгаа нь тэдний “бүрэн эрхт байдал” буюу нийтлэг хүсэл зоригийг төлөөлөх эрхийн хууль ёсны шинжээр илэрнэ.

Монголын их хаадын захидлаас нийтлэг байдлаар харж болох нэг утга нь захидлаар харилцагч тодорхой этгээдийн хувь хүсэл зориг гэхээс илүү нийтлэг хүсэл зориг, ашиг сонирхол илэрхийлэгдсэн байдал юм. Захидлуудад биеийн төлөөний үгийг нэг, хоёрдугаар биеийн олон тоон дээр хэрэглэсэн байдаг. Монголын их хаан Гүюгээс Ромын Пап IV Иннокентэд илгээсэн хариу захидал, Мөнх хаанаас Францын ван Людовикт илгээсэн захидал болон Өлзийт хаанаас Франкын султанд илгээсэн захидлууд “бид”, “та нар” гэсэн төлөөний үгсээр харилцсан бол Ил хаан Аргунаас Францын гоо ван Филиппэд илгээсэн захидалд “бидний үг” тодотгол хэрэглэсэн нь бий.

Захидлуудад биеийн төлөөний үгийг олон тоон дээр хэрэглэсэн нь захидлаар илэрхийлсэн утгууд буюу санаа бодол, шийдэл, хүсэл зориг нь нийтлэг бөгөөд захидал илгээгч тухайн нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөн захидал илгээх эрхтэй байсныг тодорхойлж байна. Захидлуудын агуулгаас үзэхэд, дурдан буй “нийтлэг” гэдэг нь нэг бүлэг хүмүүсийн гэхээсээ “нийт улс орныг” төлөөлөн бичигдсэн байна. Мөнх хаанаас Францын ван Людовикт илгээсэн захидалд, “...Монгол, Найман, Мэргид бид бүгдээс та бүхэнд хэлэх үг ману...”, “...Их монгол түмний нэрийн өмнөөс франкуудын эзэн ноён Людовик ван болон бусад эзэд, санваартан, их Франк түмэнд хүргэх Мөнх хаан ману зарлиг Энэ болохыг мэдтүгэй...” гэж, Хубилай хаанаас Японы эзэн хаанд илгээсэн захидалд /төрийн бичиг/, “Их Монгол улсын хаанаас Япон улсын ванд илгээх бичиг...”, “...хөрш улстайгаа найрсаг харилцаа тогтоох нь сайхан хэрэг болой...” гэж, Өлзийт хаанаас Франкын султанд илгээсэн захидалд, “Эртнээс Франкуудын султан та бүхэн бидний сайн элэнц, сайн өвөг, сайн эцэг, сайн ахтай найрамдаж хол боловч ойр мэт санаж аливаа үгсээ өчиж элчингүүдээ (болон) эсэн мэндийн бэлгээ солилцож ирснийг яахин умартах буй...” зэргээр улс орны нийтлэг эрх ашгийг төлөөлөн, ийнхүү төлөөлөх эрх нь хүлээн зөвшөөрөгдсөн этгээдээр дамжуулан илэрхийлэгдэж байв.

Ийнхүү зарлиг захидал бичих, илгээх эрхийг олгон баталгаажуулах хууль зүйн процесс нь хаан ширээнд залгамжлах их хуралдайн зохион байгуулалт, эрх хэмжээгээр баталгаажиж байв.

Ил хаан Аргунаас Ромын Пап IV Николод илгээсэн захидалд Эл хаан Аргуныг христос шашинд оруулах болзлыг Папаас тавьсан бөгөөд үүнд Аргун “өөрийн

³⁰ Морис Дюверже. 2007. 44-45.

монголчуудыг *христос шашинд ороход саад хийхгүй, хаан өөрөө христос шүтлэгтэнд орохгүй*” гэдгээ илэрхийлж “*Чингис хааны үрс бид ямар шашин шүтэхээ хэнээр ч заалгахгүй, ямар шүтлэгтэй байх нь гол бус, шүтлэгтээ үнэнч байж сайн үйлс бүтээх нь чухал*” хэмээн хариулж байв. Ингэснээр хувь хүний эрх зүйн байдлыг төлөөлөх, нийт улс орны эрх ашгийг эрхэмлэхийн ялгаа заагийг нарийвчлан тусгаж, эдгээр эрхийн ялгаа заагийг тодорхой илэрхийлсэн гэж үзэж болно.

Монгол хаадын захидал нь хаадын эрх мэдлийн /эзэн эрхийн/ хууль ёсны баталгаа болсон бүрэн эрхт байдлыг бусдад /бусад улс орны хаад, ван, шашны тэргүүн зэрэг эрх мэдэлтэнд/ батлан харуулсан илэрхийлэл байв.

Хаадын хууль ёсны эрх мэдэл нь, энэхүү эрх мэдлийнхээ хүрээнд бусдад эрх, үүрэг хуваарилах явдлаар илэрнэ.

Эрхийн талаарх мета онолчдын үзсэнээр эрх мэдэл нь товчхондоо бусдад хамаарах үйлдэл хийх эрх буюу бусдын эдлэх эрх, хүлээх үүргийг хуваарилах эрх юм.

Эрх зүйн философич Джон Остин /1863 онд бүрэн эхээр нь хэвлүүлсэн *Lectures on Jurisprudence* бүтээлд/ өөрт хамаарах үйлдлийн мета онол дээр суурилсан аналитик системийг зохиосон байна. Эрх болон үүрэг нь хуулийг бүтээх буюу тухайн бие даасан нийгэм дэх Эзэнт гүрний тушаалаас үүдэлтэй юм³¹ хэмээн тайлбарлаж, тушаалаар хүмүүст ямар нэгэн зүйл хийх, эсвэл түүнтэй холбоотой үүрэг даалгавар өгөх ба үүрэг бол эрхийн үндэс гэж үзсэн. Дээрх утгыг дэлгэрүүлж гэвэл философич, хуульч Жереми Бентам болон Жон Стюарт Миллийн тайлбар, эрх үүргийн талаарх Хохфелдийн загварыг ч нэмж болохоор санагдана.

Эрх мэдлийн утгыг ийнхүү дэлгэрүүлэх зорилго нь, бусдын эдлэх эрх, хүлээх үүргийг хуваарилах шинж байгаа эсэхийг дурдан буй хаадын захидлын утгаас эрэн хайх явдал юм.

Хаадын захидлуудын одоогоор олдож буй агуулгыг анзаарахад, юуны өмнө эрх зүйн харилцааны агуулга гэж үзэхээр эрх, үүргийн хуваарилалтууд ажиглагддаг.

Захидлууд нь тухайн түүхэн цаг үеийн үйл баримттай холбогдуулан харилцан хүсэл зориг илэрхийлэх замаар эрх, үүргийг хуваарилж байсан гэж үзэх талтай. Тухайлбал, хаадын захидал харилцааны хамгийн эхэнд бичигдэх Ромын Пап IV Иннокентийн захидалд Монголын их хаан Гүюгээс 1246 оны 11 дүгээр сард илгээсэн хариу захидалд,³² “*иргэн болох, эд орга өгөх*” үүрэг, “*ивээлд орох*” үүрэг, “*зарлиг дагах*” үүргийг заавал биелэгдэх шинжтэйгээр захидал хүлээн авагч талд ногдуулж, түүнийг зөрчвөл “*дайсан гэж үзэх*” хийгээд ямар үр дагаварт хүргэх нь захидал илгээгч талаас хамаарахаар тусгасан байна.

Энэ нь эрх мэдэл хэнд хамаарах, хэн хэний өмнө тодорхой үйлдэл заавал хийх үүрэгтэй байх, зөрчвөл үр дагаврыг үүрэгтэй бус эрх мэдэлтэй тал нь шийдвэрлэх зэргээр эрх-үүргийн тодорхой хамаарал бүхий эрх зүйн харилцааны утга агуулгын илэрхийлэл болж байв.

Тодорхой эрх, үүргийг харилцан хуваарилах, үүсэх үр дагаврыг “хууль ёсны дагуу” үүрэг зөрчсөн талд хариуцуулах “эрх зүйн хэм хэмжээний” шинжийг Францын

³¹ J.Austin. *Lectures on Jurisprudence*, London. J.Murray, 1861-1863, 61.

³² Эл захидлын хоёр өөр орчуулга байх ба Судлаач Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат нарын бүтээлд ашигласан хувилбарт шинжилгээ хийгдэв.

ван Людовик өөрийн нууц элч Гильом Рубрукаар илгээсэн захидалд Мөнх хаанаас хариу илгээсэн захидлаас харж болно.

Захидалд “...Ману зарлигийг сонсож, ухсан атлаа үл биширч ману өөдөөс цэрэг хөдөлгөх аваас тэр нүд байвч харж эс чадах, гар байвч барьж эс чадах, хөл байвч явж үл чадахыг сонсох буй за...” хэмээж тодорхой ямар үйлдэл заавал хийх, эс хийхийг, “...Их монгол түмний нэрийн өмнөөс франкуудын эзэн ноён Людовик ван болон бусад эзэд, санваартан, их Франк түмэнд хүргэх...” гэж тодорхой ямар этгээдэд хамаатуулан, “Тийнхүү та нар мануустай дайтах, найрамдахын алин болохыг бид мэдсүгэй...” гэж зөрчвөл хэрхэх, зөрчихгүй бол хэрхэх тухай үр дагаврыг тодорхойлсон нь бий.

Эл номын эхний бүлэгт өгүүлсэнчлэн хаадын албан захидал буюу “зарлиг захидал” нь дээр тодорхойлсноор эрх, үүргийн хуваарилалтын шинжээс хамааран тодорхой төрлүүдэд ангилагдаж болохоор байна.

Дээрх саналыг бататгах үүднээс үгийн утгад дахин тодруулга хийе.

Эзэнт гүрний үед хамаарах хаадын захидал харилцаа нь, -гадаад улс орнуудын хаад, эрх баригчдын шашны бодлого, шийдвэрт хариу өгөх, - цэрэг, дайны ажиллагааны талаарх төрийн бодлого, эвсэн довтлох санал хүсэлтээ урьдчилан илэрхийлэх хүрээнд өрнөж байв. Тухайн асуудлаар захидал илгээх, захидалд хариу өгөхдөө эрх зүйн арга, механизмын хувьд өөр өөр бодлого баримталж байсан нь захидал дахь үгийн сонголт, хэл бичгийн соёлоос харагдана.

Хаадад илгээсэн захидалд хариу захидал илгээхдээ, “мэдтүгэй”, “үзсүгэй”, “зарлиг буй бөлгөө”, “биширтүгэй”, “дагатугай”, “бидэнд илгээгтүн”, “бид мэдсүгэй” гэсэн үгийн сонголтнууд хийсэн нь захиран тушаах, захирагдах аргын илэрхийлэл болж байгаа бол анх тутам захидал илгээх, үргэлжилсэн захидал харилцаанд “найрсгаар харилцахыг хичээнгүйдэг бөлгөө”, “мөхөс би сэтгэлээ илэрхийлэн хүсэх нь үүнээс хойшид харилцан мэндчилэн найрсаг харилцаа тогтоохыг хүснэм”, “Ван та тунгаан бодолхийлтүгэй”, “хөрш улстайгаа найрсаг харилцаа тогтоох нь сайхан хэрэг болой”, “Ван сайтар ухагтун”, хэмээн үг хэлэлцэн тогтов, найрамдаж харилцсаныг яахин бид огоорох билээ, “Үнэн хүү зохилдохоос сайн юу байх билээ” зэрэг харилцан санал бодлоо илэрхийлэх, хариу хүсэх, хэлэлцэх тохиролцох, зөвшилцөх утгуудыг найрсгаар илэрхийлж байв.

Харилцан хүлээх үүрэг, эдлэх эрх, хариуцлагыг анх тутамд үүсгэх, харилцааг үргэлжлүүлэх болон өөрчлөх, эсхүл дуусгавар болох хүсэл зоригийн илэрхийллүүд өөр өөр өнгө аяс, үг өгүүлбэрээр илэрхийлэгдэж байснаас үзэхэд “үүрэг болгосон”, “эрх олгосон”, “зөвшөөрсөн”, “хориглосон” хэм хэмжээг бичиж илэрхийлэх хэлний соёл, техникийн чухал эх сурвалж гэж үзэх үндэслэлтэй байна.

Дээрх товчхон шинжилгээгээр Монгол хаадын захидалд хаадын эрх мэдлийн хууль ёсны шинж болох эрх, үүргийн хуваарилалт, түүнийг зөрчвөл үүсэх хууль зүйн үр дагаврыг тодорхойлсон утга байгааг анзааран хэм хэмжээний бүтцийн шинжтэй байжээ гэсэн санааг хэлж болохоор байна.

2.2. Зарлиг захидал-хэм хэмжээний бүтэц

Эхэнд дурдсанаар, Б.Сумъяабаатар аругайн дурдсан хаадын зарлиг олон төрөлтэй байдаг талаарх хэсгийг эргэн саная. Ангилал бүрд байх утга нь захидлын зорилготой холбоотой хангалттай тодорхой томъёологдсон бөгөөд төрөл бүрийг /"Сургах Зарлиг", "Тархаах Зарлиг", "Ухуулах Зарлиг", "Хэлтрүүлэх Зарлиг", "Илбэх зарлиг", "Ял асуух Зарлиг"/ шууд тодорхойлж болохоор байна.

Харин эдгээр төрлүүдийн агуулгыг хууль зүйн шинжээр нь буюу эрх-үүргийн утгаар харвал, зарлигийн төрөл нь "эрх олгосон", "зөвшөөрсөн", "хориглосон", "үүрэг болгосон" зэрэг хэм хэмжээний ялгаатай үр дагавруудтай байж болох. Нөгөө талаар "тохиролцох", "зөвшилцөх", "санал илгээх", "хариу өгөх" зэргээр зарлиг илгээгчийн хүсэл зоригийн илэрхийллүүд нь хэлэлцээ хийх, хэлцэл хийх, хэлэлцээр хийх, гэрээ байгуулах, тунхаг бичиг гаргах зэрэг хууль зүйн фактын шинжээр ялгаатай байна.

Дээрх шинжүүдээр хаадын зарлиг тус бүрд шинжилгээ хийх боломжтойг дурдъя.

Хаадын зарлиг нь бүтцийн хувьд хэм хэмжээний бүтэц гэж хэлж болохоор харьцангуй нийтлэг бүтэцтэй байна.

Орчуулгын зөрүүтэй байдал болон хаадын зарим захидлын олдоц ховор, судалгаанд нээлтэй бус байдгаас хамааран хэм хэмжээний бүтцийг загварыг иж бүрэн тогтооход хүндрэлтэй байна.

Хаадын захидлын судалгаа нь хаадын захидал судлалын түвшинд тэлж, зөвхөн түүхийн судалгаа бичилтээр хязгаарлагдахгүй, эрх зүйн судлалын арга хэлбэрээр өргөжиж байгаагийн нэгэн жишээ нь түүхч, улс төрийн философич Эрик Фёгелин *1245-1255 оны үеийн Европын эрх мэдэлтнүүдэд илгээсэн Монгол хаадын зарлиг захидлууд*³³ бүтээлдээ Гүюг хаан, Мөнх хааны илгээсэн захидалд шинжилгээ хийн эрх зүйн дүгнэлт өгсөн явдал юм.

Тэрээр энэ бүтээлдээ, *"Монголчуудын улс төрийн манлайлал, эзэнт гүрний байгуулалтын үзэл санааны талаар үнэ цэнэ, ач холбогдол бүхий олон баримтууд байдаг. Тэдгээр нь 1245-1255 оны хооронд бий болсон байна. Эдгээр баримтууд нь Монгол улсын их хаад, цэргийн командлагчдаас Европын эзэнт гүрнүүд рүү түүн дундаа Пап лам болон Францын эзэн хаанд илгээсэн байдаг. Эдгээрт Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа, Монголын улс төрийн онолын хүрээ агуулагдсан байдаг."*³⁴ гэсэн тодорхой дүгнэлтийг өгсөн байна.

Дээрх дүгнэлтийг шууд хүлээн зөвшөөрсөн гэж үзэхгүй ч тус бүтээлийн цараа, эрх зүйн шинжилгээ хийсэн эх сурвалжаас үзэхэд дэмжүүштэй тал ажиглагдана.

Тухайлбал, түүний хаадын захидлын бүтцэд задаргаа хийн оршил хэсэгт хийсэн дүгнэлтдээ, *бүтцийн ижил төстэй байдлыг харуулахын тулд хэвлэмэл хэлбэрээр дараах хэд хэдэн томъёоллыг /формула/ харуулав*³⁵ гээд захидлын бүтцийг загварчлах оролдлого хийсэн нь чухал санаа юм. Түүнчлэн, *"...тухайн томъёолол нь тодорхой загвар, төлөвлөгөөний үндсэн дээр бүтээгдсэн нь илэрхий байх бөгөөд дараах хэсгүүдийг агуулсан гэж үзэж болохоор байна.*

[a]. Бурханд хандсан үг /Тэнгэр/

³³ Voegelin, Eric. "THE MONGOL ORDERS OF SUBMISSION TO EUROPEAN POWERS, 1245-1255." *Byzantion*, vol. 15, 1940, pp. 378–413. JSTOR, <http://www.jstor.org/stable/44168533>. Accessed 2 Feb. 2023.

³⁴ Voegelin, Eric. "THE MONGOL ORDERS OF SUBMISSION TO EUROPEAN POWERS, 1245-1255." *Byzantion*, vol. 15, 1940, pp. 378. JSTOR, <http://www.jstor.org/stable/44168533>. Accessed 2 Feb. 2023.

³⁵ Voegelin, Eric. 1940, pp. 393.

[б]. Хаанд хандсан үг

[в]. Бичигчийн нэр

[г]. Хүлээн авагчийн нэр

[д]. Зарлигийн хэсэг /*verbum, preceptum*/

[е]. Хүлээн авагчийн захидлыг авсныг илтгэх хэсэг.

Латин бичвэрийн дэс дараалал нь үргэлж нэг ижил байдаггүй бөгөөд аль нэг хэсэг нь эвдэрсэн эсвэл бүр алга болсон байж болох юм. Жишээлбэл 1-р формулад захидал дахь хааны нэр ижил биш байгаа бөгөөд формула 1-д эвдэрсэн хэлбэрт байгаа “*certissimas atque veras*” гэсэн үггүйгээр хүлээн авагчийн захидлыг авсныг илтгэх формула байхгүй байна” гэж дүгнэсэн байна.

Хаадын захидал судлал хэсэгт дурдсанчлан захидлын орчуулгын зөрүү нь эрх зүйн бүрэн утга тодорхойлоход сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Харин тухайн захидлын орчуулгад Пеллиотын хэвлүүлсэн эх захидлын шинжилгээ нь асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн тус нэмэр болохоор байна гэсэн нь А.Мостаэрт, Ф.Кливлз нарын 1962 оны Ил хаан Аргун, Өлзийт нараас 1289, 1305 онд Гоо Филиппт илгээсэн захидлууд бүтээлд дурдсантай³⁶ адил дүгнэлт хийгдсэн байна.

Хаадын захидлын үндсэн эх харьцангуй цөөн олдсон, олдсон эх нь бүрэн эхээрээ судалгааны эргэлтэд цөөн орсонтой холбоотой эрх зүйн бүтцийн бүрэн шинжилгээ хийхэд учир дутагдалтай ч Гүег хаанаас Ромын папад илгээсэн захидал /1245/-[1], Ил хаан Аргунаас Францын Гоо Филиппт илгээсэн захидал /1289/-[2], Ил хаан Өлзийтөөс Францын Гоо Филиппт илгээсэн захидал /1305/-[3] зэрэгт дээрх жишгээр бүтцийн задаргаа хийхэд,

	[a]	[б]	[в]	[г]	[д]	[е]
[1]	√	√	-	√	√	-
[2]	√	-	-	-	√	-
[3]	√	√	√	√	√	-

Дээрх хүснэгтээс “[в]. Бичигчийн нэр хэсэг” нь хэсэг бусад байна. Тэнгэризм үзэлтэй холбоотой зөвхөн ганц тэнгэр эзэн нь Чингис хаан гэдэг утгаар дараа үеийн хаад захидалд өмнөх хаадын нэрийг дурдан өөрийн нэрийг орхигдуулдаг байсан гэсэн санаа бодол судлаачид өгүүлдэг. Энэ шинж зарим захидлуудад ажиглагддаг ч бас түгээмэл ажиглагдах дүгнэлт гэж үзсэнгүй орхив.

Харин “[е]. Хүлээн авагчийн захидлыг авсныг илтгэх хэсэг” нь тухайн захидал бүрэн эхээр олдсон эсэхтэй холбоотойгоор дүгнэгдэнэ. Энэ талаар А.Мостэрт, Ф.Кливлз нар ч дурдсан байдаг. Зарим захидлуудад, тухайлбал, Ромын папад илгээсэн захидалд тусгай тэмдэглэгээ дарсан байдаг ч энэ нь хүлээн авагчийн бус Ватиканы архивын тэмдэглэгээ байх магадлалтай байна.

Захидлын эх хувьд тулгуурлан дээрх бүтцийн дүгнэлтийг илүү тодорхой болгох боломжтой ба дараагийн судлаачид үүнд анхаарна гэдэгт итгэнэм.

³⁶ Мостэрт А. Кливлз Ф.В. 1998, 41.

Монгол хаадын захидалд эрх зүйн шинжилгээг анх тутамд хийсэн Эрик Фёгелин судалгааны ажлаар дүгнэлт өгснийг онцлон тэмдэглэж байна. Тэрээр, “Эдгээр баримт бичгүүдийн албан ёсны онцлог шижүүдийг тогтоосноор бид тэдгээрийн утгын шинжилгээг хийх боломжтой. Миний үзэж байгаагаар зөвхөн “Захидал” төдийгүй Монголын нийтийн эрх зүй, улс төрийн үзэл санааны талаар чухал шинжүүдийг илтгэсэн эрх зүйн баримт бичиг юм. Тэдний ач холбогдлыг Монголын эзэнт гүрний хүчирхэг үеийн Монголын эрх зүйн соёлын талаарх цорын ганц үнэн бодит мэдээллийн эх сурвалж мөн гэж үздэг. Захидлууд нь Монголчуудын хуулийн процессын талаар тэдний үзэл бодол, зарим талаараа Эзэнт гүрний үндсэн хуулийн эрх зүйн үндсэн засаглалын тайлбар, мэдээллийн албан ёсны хэрэгсэл төдийгүй зарлигийг хүлээн аваад биелүүлээгүй байж болохгүйг Монгол улсын хуулийг үл тоомсорлож болохгүйг хавсаргадаг байв. Захидал дах хэрэгслүүдийн хууль зүйн бүтэц нь маш тодорхой. Эрх зүйн дүрэм журмууд нь ерөнхий дүрэм журам, материаллаг эрх зүй рүү оновчтой байдлаар өндөр түвшинд зохион байгуулагдаж, ангилагдсан байна” гэжээ.

Монгол хаадын захидал бүгд бүрэн эхээрээ олдоогүй ч, түүхэн судалгааны эргэлтэд орсон, нийгэд ил болсон захидлын агуулгын хүрээнд дүгнэн үзэхэд, захидлаар илэрхийлсэн хүсэл зориг хүчинтэй байх нь тухайн захидал бичигчийн хувийн байдалтай холбоогүйгээр /нас барах/ үргэлжилж байсан гэж хэлж болохоор байна. Чухамдаа “хууль тогтоомжийн хүчин төгөлдөр байдал”-тай нэлээдгүй төсөөтэй байгаа нь үйлчлэлийн хувьд эрх зүйн хэм хэмжээтэй адилтгахуйц болгож байна.

Тухайлбал, Ромын Папаас илгээсэн /1245 онд/ шашны бодлогын талаарх яриа хэлэлцээр 1290 онд Ил хаан Аргунаас Ромын Папд илгээсэн захидлын үеэр ч үргэлжилж байв. Улс хооронд эв найрамдлыг эрхэмлэх, эсхүл “дайсагнах” төрийн гадаад бодлогын илэрхийлэл болохуйц Монгол хаадын захидлууд дахь нийтлэг ашиг сонирхлууд нь он удаан жил хүчин төгөлдөр байдлаа хадгалж, төрийн эрх зүй, аюулгүй байдлын эрх зүй, олон улсын эрх зүйн түүхийн чухал эх сурвалж болж байна.

Эрх зүйн хэм хэмжээтэй адилтгах талаасаа түүний хүчин төгөлдөр байдлыг илтгэх тамга дардас, албан ёсны байдлын асуудал ихээхэн чухал болно.

Монгол гүрний эзэн хааны тамга, дардасны судалгаа өргөжиж байгаа ч энд анхдагч гэж болох судалгааны дүгнэлтийг тусгайлан дурдах нь зүйтэй байна. Тодруулбал, нэрт эрдэмтэн Д. (Х) Пэрлээ, *Монгол гүрний эзэн хааны тамга байдлыг төсөөлж болох ганц баримт бидэнд байна. Энэ нь Монголын хаан Гүюгийн Ромын пап ламд 1246 онд илгээсэн бичигт дарсан тамганы дардас билээ. Уг тамганы хэмжээ: 14,5x14,5 см, зургаан мөр монгол үсгийн бичээстэй. Тамгыг францын нэр өндөр нангиадач П. Пеллио шинжиж бичээсийг уншсан нь:*

“Мөнх тэнгэрийн
Хүчинд их Монгол
Улсын далай-ийн
Ханы зарлиг, Ил булха
Иргэнд хүрвээс
Биширтүгэй, аюутугай” гэжээ.

Тамганы дардсыг сайн ажиглаваас “далай-ийн” биш “далай эзэн” гэсэн үг бололтой. Учир нь тамганы үсгийг сийлэгч хүн “эзэн” гэсэн үгийн дараах “э” эгшигийн

нэг шүдийг, “н” төгсгөлийн нэг шүдийг орхигдуулсан нь байдалд илэрхий. Далай эзэн гэх нь их эзэн гэсэн утгатай ажээ³⁷ гэв.

Энэхүү номын 2 дугаар бүлэгт дурдсанаар, Чингис хаанаас Чанчунь бомбыг дагалдан илгээх зарлигийн төгсгөлд, ...

Үүний тул зөвшөөрөв.

хааны³⁸

Харагчин хонин жилийн гурван сарын ...өдөр

эрдэнэ”

“Хааны эрдэнэ” гэдэг нь хятадаар хааны тамгыг нэрлэдэг байжээ. Энэхүү зарлиг бичгийн эх дээр Чингис хаан тамгаа дарж баталгаажуулсан байна. Их хааны тамгыг зарлигийн төгсгөлд он сарын дээр дарсан байжээ. Хожим нь зарлигийг чулуунд сийлэхдээ их хааны тамганы дардас байгаа газар нь “хааны тамга” /хааны эрдэнэ/ гэсэн үгийг сийлсэн байна³⁹.

Энэ нь нэг талаас төрт ёсны илэрхийлэл, нөгөө талаас захидлын буюу зарлиг захидлаар илрэх хэм хэмжээний хүчин төгөлдөр байдлын албан ёсны баталгаажилт юм.

2.3. Заншлын эх сурвалжийн хэв шинж захидлуудад тусгагдсан нь

Монгол хаадын захидалд байх нийтлэг нэг утга нь захидлаар илэрхийлэгдэх нийтлэг хүсэл зориг улс орон, ард иргэдэд хамааралтай байхаас гадна Тэнгэрээс илгээгдсэн байх утга юм.

Монголын эзэнт гүрний үед Тэнгэрийн үзэл жинхэнэ утгаараа Тэнгэрчлэх үзэл бодол хувирч, дэлхийн бусад шашин, улс төрийн томоохон үзэл сурталтай шууд өрсөлдөн тэмцэх болсон гэж зарим судлаачид үзэж байна. Тэнгэрийн үзэл нь бөөгийн шашны үзэгдэл үү, аль эсвэл бие даасан шашин мөн үү гэдэг асуудал эдүгээ маргаантай хэвээр байна. Эзэнт гүрний үе дэх ислам болон христос шашны байр суурийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай⁴⁰.

Мөнх тэнгэрийг шүтэх ёсон эртнээс улбаалан эзэнт гүрний үед эрчимжиж байсны ул мөр Их хаадын захидалд гүн гүнзгий тусгалаа олсон байна. Захидлууд дахь “мөнх тэнгэрийн хүчин дор”, “тэнгэрийн бошгыг дагах”, “тэнгэр мэднэ”, “тэнгэрт залбирч”, “тэнгэрийн хишгээр”, “мөнх тэнгэрийн тогтоосон зарлиг”, “мөнх тэнгэрээс Чингис хаанд буулгасан бошго сургаалыг”, “тэнгэрийн хүчинд”, “тэнгэрийн соёрхлыг” гэсэн утгууд нь захидлын эхэнд болон төгсгөлд хүч нэмсэн, түүнчлэн тодорхой үйлдэл, эс үйлдлийн заавал биелэгдэх шинж буюу үүргийн хэсэгт хүч нэмэх, эрх мэдэл олгогдож байгаа талын сүр хүчийг нэмэгдүүлэх, дагаж мөрдөөгүйн улмаас гарах хариуцлага, шийтгэлийг “үл маргах” журмаар ногдуулахыг хангалттай тодорхой илэрхийлж байгаа хэрэг юм.

Юуг шударга, юуг шударга бус гэж үзэх тухай тэнгэрийн үзэл нь бөө мөргөлийн тусламжтайгаар зөвхөн хаадын хүсэл зориг, зарлиг шийдвэрээр дамжин илэрхийлэгдэх тул зарлиг шийдвэр, захидал бичээст тусгалаа олохдоо хууль зүйн хувьд “үл маргах”,

³⁷ Пэрлээ Д /Х/. Монголын тамга зүйн асуудал.

³⁸ Ганбаатар Ц., Дэлгэржаргал П. Чингис хаанаас Чан Чунь бомбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн зарлиг. Түүхийн судлал XXXVI боть. Уб., 2006, 52.

³⁹ Ганбаатар Ц., Дэлгэржаргал П. 2006. 49-52.

⁴⁰ Шагдар Х. Дашдаваа Ч. Монголын эзэнт гүрний тухай Монголын орчин үеийн түүх бичлэг. Түүхийн судлал. XXXVIII боть, Уб., 2008, 117-118.

“эцсийн шийдвэр байх”, “заавал биелэгдэх шинжтэй байх” гэсэн утга бүхий гэж үзэх талтай.

Чингис хааны бусад улс орны хаад, шашны тэргүүн болон эрх мэдэлтнүүдэд илгээсэн захидалд тэнгэрийн бошгийг дээр дурдсан хэллэгүүдээр сүр хүчтэйгээр илэрхийлэх нь ховор /судлаач захидлын мэдээллийг дутуу ажигласан байж болох/. Харин түүний дараа үеийн хаадаас эхлэн захидлын оршил хэсэгт мөнх хөх тэнгэрт хандсан утгууд ажиглагддаг. Энэ талаар Б.Сумъяабаатар абугай тэмдэглэсэн талаар дурдаж байсан билээ.

Нэг талаас хаад бүр өөрийн эзэн эрхийн хүрээнд эрх мэдлийг хэрэгжүүлж байсан ч нөгөө талаас бүгд өөрийгөө тэнгэр мэт үзэх агуулга бус харин зөвхөн нэг л тэнгэр буюу Чингис хааныг төрийн хэрэг, захидал харилцаанд дурдан алдаршуулж явсан хэрэг биз.

Тэнгэрийн үзлийн талаарх судалгааны бүтээл арвин байна. Түүн дотроос энэ үзлийн мөн чанар, утга санааг монгол хаадын захидлын агуулгаас эрэн хайж дүгнэлт хийсэн нь бий. Тухайлбал, нэрт эрдэмтэн Ш.Бира, “Тухайн цагийн Монгол хаадын зарлиг зэрэг баримт бичгүүдээс үзэхэд Монголын Тэнгэрийн үзэл нь Хубилайн үеэс Бурхан Буддагийн шашныг дээдлэх болсон хэдий ч өмнөх хаадын үед Христ, Исламын шашинтай тэрсэлдэж байсан шиг бусад шашнуудыг гадуурхан үзэж дайсагнаж байсангүй болохыг зориуд тэмдэглэвээс зохино. Тэр ч бүү хэл Тэнгэрийн үзэл нь Буддагийн үеийн суурь баримтлалуудын нөлөөгөөр үлэмж өөрчлөгдөн хувирсан болой.”⁴¹ хэмээв.

Хаадын захидал харилцаанд хүч нэмэн далайлгах, эвсэн найрах, уяран зөөллөх олон өнгө аяс буй. Ялангуяа шашны бодлогын хүрээнд хэлэлцсэн захидлуудад ийм өнгө аяс холилддог.

Чингис хааны Чанчунь бомбод илгээсэн захидал нь утга төгөлдөр, уран яруу өнгө аясаар урин залсан утгатай гэдгийг тэмдэглэн хэлсэн. Гэвч энэ өнгө аясын цаана зөрж үл болох албадлагын шинж байсан. “Чанчунь бомбо хангайн үзэсгэлэнт нурууг эгцлэн давж, Алтайн өвөрт ирж Чингайн балгасанд 7 дугаар сарын 25-нд хүрсэн байдаг. Чингайн тэнд тариа ногоо тарьж ургуулсан байдлыг нүдээр үзэж ихэд гайхан, бас Чингай ноёнтой ярилцсан байдлаас Монголын эзэн хаан Чингисийн урилга бол урилга, үг бол үг, тэр хуулийг хэн ч үл зөрчих байдлыг олж мэдсэн”⁴² талаар дүгнэсэн нь бий.

Тусгаар улс орны эрхэм зүйлсэд хамаарах утгаараа шашны бодлого ихээхэн эмзэг. Монголын хаад, ялангуяа Чингис хаан энэ эмзэг талыг торгон мэдэрч сэтгэлийн гүнд хүрэх дөт арга болгон ашиглаж байв.

Чингис хааны тус бие нь ямар нэгэн шашны сүсэгтэн биш учир аливаа шашныг тэгш эрхэмлэж зүй зохистой ном сургаалыг нь хөхиүлэн дэлгэрүүлэхийг баримталжээ. Хэрэв тэр аль нэг шашны үнэнч сүсэгтэн байсан бол шашин бүхэнд тэгш хандаж чадахгүй юм. Жинхэнэ шашинтанд авч хэлбэл өөрийн шашнаа л дээдлэн хүндэтгэдэг нь түгээмэл үзэгдэл байлаа. Нэлээд хүмүүс Чингис хааныг бөөгийн мөргөлтнөөр үздэг нь жинхэнэ шашныг шүтэгч ба ашиглагч хоёрын ялгааг хутгалдуулан ойлгосноос болсон байна. Чингис хаан зарим үед үнэхээр сүсэгтэн шиг жүжиглэдэг нь зөвхөн хүний сэтгэлийг хураах хэрэгцээнээс л болсон гэдгийг түүний үг яриа үйл ажиллагаагаар

⁴¹ Бира Ш. Монголын тэнгэрийн үзэл. Уб., 2011. 71.

⁴² Их Монгол улс. Уб., 2006, 175.

нэгэнт⁴³ нотлогдсон тул энд дэлгэрүүлэн тайлбарлах шаардлагагүй мэт санагдана гэсэн нэгэн эрдэмтний дүгнэлтийг энд онцлон дурдах нь зүйтэй. Үүнийг ч бусад орны судлаачид хүлээн зөвшөөрч, Чингис хаан зөвхөн нэг бүтээгч, нэг л бурхныг шүтэгч байгаагүй⁴⁴ талаар дүгнэдэг.

Хаадын захидал харилцаанд тод томруун илрэх тэнгэрийн үзэл нь Чингис хааныг “биед хатуу, сэтгэлд зөөлөн хандах” буюу төр-шашны зохист ухаантай холбон тайлбарлаж болох юм.

Тэнгэрт шүтэх дээд ухамсраас үүдэлтэй заншлын хэм хэмжээ нь хаадын төрт ёсны үзэл сэтгэлгээний дэмжлэгээр эрх зүйн хэм хэмжээний сурвалж болдгийн нэг илрэл нь дээр дурдсан хаадын захидлын үг, өгүүлбэр бүрээс тодорхой харагдана.

2.4. Хаадын захидал ба олон улсын эрх зүйн хэм хэмжээ

Монгол хаадын захидал харилцаа, ялангуяа гадаадын улс орнуудын эзэн хаан, ван, шашны тэргүүн болон эрх мэдэлтнүүдэд илгээж байсан албан захидал, зарлиг захидал нь бүхэлдээ монгол улсын гадаад бодлогыг тодорхойлох түүхийн болон эрх зүйн чухал эх сурвалжууд юм.

Монголын эзэнт гүрний бодлогод түүхэн бодит нөхцөл шалтгааны улмаас эзэрхэг түрэмгий шинж илэрч байсан хэдий боловч, дундад зууны олон улсын харилцааны эрх хэм хэмжээг хүндэтгэж байсан төдийгүй, түүнийг зарим дэвшилтэт шинж төрхөөр баяжуулж байсан бөлгөө. Тухайлбал, төр ёс, эзэн хаандаа үнэнч байх, төрийн элчийн аюулгүй байдлыг хангаж, хүндэтгэн харьцах, олон улсын болон улс орон тус бүрийн дотоодод энх амгалан байдлыг сахих нөхцөлийг бий болгох, тухайн угсаатны шашин, суртлын чөлөөт байдлыг хангаж, тэгш шударга хандах зарчмыг монгол хаад түлхүү баримталж, эзэнт гүрний хязгаарт нэвтрүүлэхийг хичээж байжээ. Тухайлж хэлбэл, энэхүү “алтан үе”-ийн олон улсын харилцааны философи нь дэлхийн эх газрын их зонхид улс төр, шүтлэг биширэл, олон үзэл бодлын найралт ёс, нээлттэй чөлөөт байдал тогтоох хандлага бүхий байлаа. Түүхэн цаг үеийн эрхээр энэ гүн ухаан өдгөөгийн олон улсын харилцаанд гүнзгий илэрч байна⁴⁵ хэмээн нэрт түүхч Ж.Болдбаатар онцлон дүгнэв.

Монгол хаадын захидлуудын утга агуулгаар гадаад бодлогын чиг хандлагыг бүхэлд нь тодорхойлох боломжгүй ч газар нутаг, хүн амыг тэлэх “төрийн бодлого”, эзлэн авсан хүн ардын олон соёлыг тэгш хүндэтгэх “шашны бодлого”-ыг хэрэгжүүлж байсан гэж үзэж болох юм. Эдгээр бодлогыг хэрэгжүүлэх үед улс хоорондын албан харилцаанд эв найрамдал, ёс төрийг /дипломат ёс/ эрхэмлэх, эвсэн нэгдэх, зөвшин хэлэлцэх, урин залах, ухааруулан сануулах олон талын арга зарчим баримталж байв.

Олон улсын харилцаанд Хүннүгийн үеэс тогтсон элчин харилцаа, гэрээ хэлэлцээр байгуулах үйлдэл өргөн байснаас гадна гэрээний дагуу хүлээн авсан үүргээ

⁴³ Пунсаг А. Чингис хаан хийгээд Монголын уламжлалт соёлын зарим асуудал. Түүхийн судлал. XXXVII боть, Уб., 2007, 63.

⁴⁴ van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p118*

⁴⁵ Болдбаатар Ж. Монголын эзэнт гүрэн: үүсэл, цэцэглэлт, мөхөл. Түүхийн судлал. XXXV боть, Уб., 2004, 57.

хэлбэрэлтгүй дагаж мөрдөх зарчим (pacta sunt servanda) бий болсон⁴⁶ байна. Энэ мэтчилэн олон улсын харилцаанд уламжлан ирсэн заншлын хэм хэмжээ нь эзэнт гүрний үед өргөжин тэлж, Чингис хаан ширээнд суух үеэс тодорхой стратегид шилжсэн гэж үзэж болно. Чингис хаан ширээнд суусан Зарлан тунхагласан бичигт:

“Миний бие 13 наснаас дөрвөн зүгийн далан хэдэн самуун улс, 12 дураар байсан хааныг дайлж 32 жил зүтгэж умард газрыг энх түвшин нэгэн гэр болгосонд түмэн улсын нийт бээр мөхөс хүн намайг эрдэмгүй бөгөөтөл эгнэгт дайсныг дарж, түмэн газрыг амар болгов хэмээн олныг хамааруулахын тулд хүндлэн өргөж хаан сууринд суулгаж улсын нэрийг хүндлэгдэхүйн дээд Хөх монгол улс хэмээн хэлж, миний биеийг Чингис хаан хэмээн нэрийдэв. Тийнхүү мөхөс хүн би зуун түмэн улс иргэний тул зүдэж зовохыг үл санан аргагүй тэнгэрийн бошиг соёрхлыг дагаж хаан оронд сууж хол ойр улс аймагт зарлан сонсгов. Товчлон үзвээс тэнгэрт сөрөгчдийг мөхөс хүн эрх биш биеэр дайлан арилгана.

Тэнгэрийг дагагчдыг мөхөс хүн хүндлэн өргөнө. Үүний тул манай их монгол улсаас дараалан Сүн улс, Хятадын Алтан улс, Жич: Ляо улс, Ся улс, Солонгос, Түвд, Балба, Каишкар зэрэг их улсуудад зарлан сонсгон явуулав⁴⁷” гэжээ.

Судлаач Ж.Бор, Монголын Хөх төрийн эзэд Чингисийн үйл ажиллагаагаар дамжуулан,

- *Олон улсын харилцааны дипломатын эрх зүйн салбарт:* -элчийн амь нас, бие дархан халдашгүй, -гэрэгэ (дипломат паспорт, итгэмжлэх жуух бичиг) шийтгэн олгох журам, элчийн дэв зэрэг (консулын ранг),

- *Улс хоорондын харилцааны салбарт:* -эрх тэгш харилцах, -бусдын хэрэгт эс өнгөлзөх, -улсын хил, нутаг дэвсгэр дархан халдашгүй байх,

- *Дайны эрх зүйн салбарт:* -дайныг эхлэхийн өмнө урьдчилан заавал зарлах, - дайныг шударгаар хөтөлж явуулах, -шаардлагагүй үед илүү цус урсгахыг цээрлэх (хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшдийг үл хөндөх), -хот балгадыг хэт улайран үл сүйтгэх, -түүх, соёлыг эвдэж сүйтгэхгүй байх,

- *Олон улсын эдийн засгийн харилцааны салбарт:* -чөлөөт худалдааг дэлхий даяар түгээмэлжүүлэх зэрэг 12 зарчмыг хэрэгжүүлж байсан нь аажмаар одоогийн олон улсын эрх зүйн зарчмуудын үндэс нь⁴⁸ болсон гэж үздэг.

Харин Өрнө зүгийн улс орнууд монголчуудын улам бүр өсөн нэмэгдэх хүчин чадал, өрсөлдөх чадвар, болзошгүй довтолгооны аюулаас сэргийлэх, найрамдан холбоотон болж өрсөлдөгч нарынхаа тэмцэлд ашиглах зорилготой байсан бол Ромын пап “Ертөнц дахины чуулган” гэгчийг хуралдуулах, монголын түрэмгийллээс Өрнө дахиныг сэргийлэн хамгаалах, ертөнцөд ноёрхлоо тогтоосон “дэлхий дахины улс”-ыг байгуулах, монголчуудыг христийн шашинд татан оруулах бодлого баримталж байжээ.

⁴⁶ Жүгдэр Ч. Хүннугийн түүх соёл. Уб., 2011. 134.

⁴⁷ Инжинаш В. Хөх судар. 1290-1291.

⁴⁸ Бор Ж. Монгол Улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал хашилага давах боломж. Уб., 2022. 238.

4. Дүгнэлт

Дээр дурдсан үйл явдлыг бүхэлд нь үнэлэн дүгнэх нь илтгэлийн зорилго, агуулгаас хэтийдэх өргөн цар хүрээтэй учир захидал харилцаанд хамаарах дээрх ач холбогдлыг түр орхин хаадын гадаадад илгээсэн албан захидал буюу зарлиг захидлаас олон улсын эрх зүйн бодлогоор дамжуулан эрх зүйн хөгжилд нөлөөлөхүйц хоёр утга байгааг дурдъя.

Нэгд. Хаадын захидал гадаад харилцаанд Их засаг хуулийг түгээн дэлгэрүүлэгч байсан баримт бий. Тодруулбал, Хубилай хаанаас Солонгост илгээсэн жуух бичгийн дотор Их засгийн хэсэг заалт орсон хэмээн Б.Сумъяабаатар абугай үзэн орчуулж нийтлүүлжээ. Тэрхүү жуух бичигт:

*“Ману Тайзу Чингис хааны айлдсан Засаг-т өгүүлэхдээ:
Нэхэн санаваас, элсэн улс болбаас Данж барих бөгөөд
Цэргээс туслах бөгөөд Хүнс нийлүүлэх бөгөөд
Өртөө байгуулах бөгөөд Өрхийн цэсийг өргөх бөгөөд
Даругачи тавих болмуй”* хэмээсэн буй шүү гэжээ⁴⁹.

Энэ талаар гаднын улс орны судлаачид тусгайлан дүгнэсэн нь, “Хятадын эх сурвалжууд болон Монголын нууц товчоон дээр үндэслэн судлаач Де Рачевильц Их засаг гэсэн хууль эрх зүйн код байдаг гэж үзэх хангалттай нотлох баримт байгаа бөгөөд ямар нэг бичмэл байдлаар Чингис хааны мэдэлд байсан гэж үзжээ. Тэрбээр мөн өөр нэг үндэслэл болгон гурав дахь их хаан Гүюг хаанаас (1246-48 онд) Ромын Пап лам IV Иннокентид (1243-54) илгээсэн эртний (1246) захидлыг онцлон тэмдэглэсэн байна. “Агуу Ромын Пап лам та амлалтаа биелүүлж бүх хаадын хамт биечлэн ирж, бидэнд хүндэтгэл үзүүлэх ёстой. Дараа нь бид та нарт Яса (Их Засаг)-гийн бүх тушаалыг сонсох болно.”⁵⁰ Морган 2005 онд уг асуудлыг дахин авч үзэхдээ, 'яса-д Өгөдэй, Гүюгийн үйл ажиллагааг зохицуулсан ёслолын болон тусгай зохицуулалт агуулж байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн.⁵¹ Мөн тэрээр уялдаа холбоо бүхий төрөлжсөн хууль байсан гэдэгт итгэхгүй байсан хэдий ч "ямар нэгэн зүйл байсан" гэдгийг хүлээн зөвшөөрсөн байдаг.⁵² гэсэн хэсгүүдийг онцлов.

Захидал харилцаагаар дамжуулан гүйцэтгэж байсан олон улсын эрх зүйн дээрх жишиг өнөөгийн нийгэмд ч ихээхэн чухал, дахин давтууштай байна.

Хоёрт. Хаадын захидал нь олон улсын шинжтэй гэрээ, хэлэлцээрүүд батлагдах үндэслэл, нотолгоо болсон. Тухайлбал, 1253 онд Хархорумд Мөнх хаан, Армяны ван II Гетум нарын байгуулсан гэрээ ёсоор Армяны ван Мөнх хааныг христийн шашинд дагаар

⁴⁹ Сумъяабаатар, Б. Монголын Нууц Товчоон, Уб., 2020. 2221. Данж барих нь алба барих, барьцааны хүн илгээх гэсэн хоёр утгатай бөгөөд энд барьцааны хүн илгээх гэсэн утгаар орсон байгааг Б.Сумъяабаатар нотлон тайлбарласан байна.

⁵⁰ Igor de Rachewiltz, 'Some Reflections on Činggis Qan's Jasaγ', *East Asian History* 6 (1993):100. (Based on Boyle's translation of the Persian version of the letter in P. Pelliot, 'Les Mongols et la papauté', *Revue de l'Orient chrétien* 23, no. 30 [1922-1923]: 15-16. The Persian quote is found on p. 15, ll. 9-10.) On the Yasa in Chinese legal sources, see Paul Heng-chao Ch'en, *Chinese Legal Tradition under the Mongols: The Code of 1291 as Reconstructed* (Princeton: Princeton University Press, 1979), 4-10.

⁵¹ Morgan, 'Revisited', 303 cited in van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East*. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p122

⁵² Morgan, *The Mongols*, 98. See also Morgan, 'The "Great Yāsā of Chingiz Khān"', 164-66. cited in van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East*. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p122

орох, христийн шашинтан ба монголчуудын хооронд мөнхийн найрамдал, нөхөрлөл тогтоох, монголчуудын эзэлсэн ба ирээдүйд эзлэх газар оронд христийн шашны сүм хийд, лам нарыг албан татвараас чөлөөлөх, христийн шарил байдаг Иерусалимыг перс нараас чөлөөлж христийн шашинтан нарт эргүүлэн олгох, лалын шашны манлайлагч Багдадын Халифын эсрэг дайтах, Армян ба түүний хөрш улсуудад монгол цэргийн тусламжийг хэрэгтэй цагт нь олгож байх, персүүдийн болон монголчуудын эрхшээлд орсон газар нутгийг Армянд эргүүлэн өгөх зэрэг долоон зүйлт гэрээ байгуулжээ.

Энэ мэтчилэн Чингис хаан Солонгос улстай байгуулсан Тангаргийн гэрээ зэрэг түүхэнд онцлон өгүүлсэн гэрээ, хэлэлцээрүүдийг дурдаж болно.

Ийм гэрээ хэлцлийн бичгийн мэдээллийг хаадын албан захидалд багтаан дүгнэх боломжгүй байна. Зарим нь албан захидалд хамаарах шинж бүхий, зарим хэсэг нь албан захидал, зарлиг захидлын шинжгүй нь ч бий.

Түүхэнд үлдсэн баримтаар тухайн цаг үед биечлэн хэлэлцсэн /элч илгээх үйлдэлгүй/, зөвшилцөн тохиролцсон гэрээ, хэлэлцээрийн үйл баримтууд нэлээдгүй бий. Хаадын зарим захидал нь тодорхой төрлийн гэрээ хэлэлцээр байгуулахын өмнөх хэлэлцээний үе шатыг /санал илгээх, хариу өгөх, шинэ санал хүргүүлэх зэргээр/ ч нотлох үүрэгтэй байгааг энд дурдъя. Дүгнэлтийн энэ хэсэг л гэхэд бие даасан судалгааны ажил болохоор байна.

Дээрхийн нэгэн адил олон улсын шинжтэй гэрээ, хэлэлцээрийг тоочвол үл барагдана. Цагаандай улсын хаадын зарлиг, арилжааны шинжтэй гэрээ хэлцэл ойролцоогоор 2000 орчим байдаг⁵³, Хубилай хаан Солонгос /Корйё улс/ улстай хийсэн гэрээ хэлцэл гэхэд Монголоос Корйё улсад илгээсэн 136 захидал бичиг, Корйё улсаас илгээсэн 171 захидал харилцааны бичиг буйг Б.Сумъяабаатар багшийн дурдсан зэргээр цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

Зөвхөн гадаад улстай хийсэн албан захидал буюу зарлиг захидлаар хязгаарлахгүйгээр дээр дурдсан бүхий л төрлийн харилцааны баримт бичигт суурь судалгаа хийх нь зөвхөн түүхийн судлал төдийгүй эрх зүйн судлалд чухал ач холбогдолтойг дүгнэн хэлье. Арилжаа, худалдааны гэрээ хэлцлийн судалгаанаас өнөөгийн монголын худалдааны эрх зүйн суурь үзэл баримтлалыг тодруулахаас эхлэн хувийн эрх зүйн төдийгүй үндэсний хэмжээний эрх зүйн тогтолцооны үнэт зүйлсийг гүн бат утгаар дүгнэн үзэх харьцуулсан эрх зүй судлалын хөгжилд тун чухал байна.

5. Эх сурвалж:

- Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. Уб., 1966. 271., Монгол хэлний тайлбар толь. Уб., 2018. 591.
- www.sonin.mn “Чингис хаан Чанчунь бомботой уулзсаны түүхт ой” нийтлэл, Я.Ганбаатар, 2018.10.19, <https://sonin.mn/news/culture/96285>, үзсэн: 2022.09.10
- Ledyard, G. (1963). Two Mongol Documents from the Koryŏ sa. *Journal of the American Oriental Society*, 83(2), 225–239. <https://doi.org/10.2307/598366>
- Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн үзэсгэлэнгийн каталоги монгол хэл дээр, ХБНГУ, 2010, 249.
- Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн. 2010,
- Гийом де Рубрук “Монголын эзэнт гүрэнд зорчсон нь” тэмдэглэл, Франц хэлнээс орчуулсан Т.Төмөрхүлэг, Уб.,2010.106.
- Гуулин улсын судар. 25-р дэвтэр. .

⁵³ Түүхч Д.Анхбаяртай хийсэн ярилцлагаас

- Марко Пологийн жуулчлалын тэмдэглэл, Өвөр монгол хэвлэл, Хөх хот, 1978
- Robson, M. (2006). *The Mission to China. In The Franciscans in the Middle Ages (pp. 108-118). Boydell & Brewer.*
- Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. Тэргүүн боть. Нэн эртнээс XVII зуун. Ред. Нацагдорж Ш., Уб., 1966, 298.
- BIRAN, M. (2008). *DIPLOMACY AND CHANCELLERY PRACTICES IN THE CHAGATAID KHANATE: SOME PRELIMINARY REMARKS. Oriente Moderno, 88(2), 369–393. <http://www.jstor.org/stable/25818180>*
- *The Mongols and the West. Peter Jackson. 2014.166.*
- Amitai-Preiss, R. (1994). *An Exchange of Letters in Arabic between Abaya Ilkhān and Sultan Baybars (A. H. 667/A. D. 1268-69). Central Asiatic Journal, 38(1), 11–33. <http://www.jstor.org/stable/41929455>*
- Баярсайхан Д. Хулэу хаанаас Абу Са'ид хуртэл: Ил Хаадын тухай өгүүлүүд. 2016., 91.
- Францын үндэсний архив. Парис. https://www.siv.archivesnationales.culture.gouv.fr/siv/UD/Fran_IR_055193/AI_136
- Чингис хаан ба түүнийг залгамжлагчид. Монголын дэлхийн эзэнт гүрэн үзэсгэлэнгийн каталоги монгол хэл дээр, ХБНГУ, 2010. 312.
- Францын үндэсний архив. Парис. https://www.siv.archivesnationales.culture.gouv.fr/siv/UD/Fran_IR_055193/AI_137
- Ганхуяг Д. Баатархуяг А. Монголын түүх бичлэг ба түүхийн социологийн асуудлууд. Монголын түүх судлал: түүхийн философийн шинэ хандлага, тулгамдсан асуудлууд симпозиумд тавьсан илтгэл. Илтгэлийн хураангуй. Уб., 2014.
- Морис Дюверже. Улс төрийн байгууламж /Үндсэн хуулийн эрх зүй/. Орчуулгын редактор Т.Төмөрхүлэг. Уб., 2007. 30-34.
- Пунсаг А. Чингис хаан хийгээд монголын уламжлалт соёлын зарим суудал. Түүхийн судлал. XXXVII боть. Уб., 2007. 63.
- J.Austin. *Lectures on Jurisprudence, London. J.Murray, 1861-1863, 61.*
- Voegelin, Eric. "THE MONGOL ORDERS OF SUBMISSION TO EUROPEAN POWERS, 1245-1255." *Byzantion, vol. 15, 1940, pp. 378–413. JSTOR, <http://www.jstor.org/stable/44168533>. Accessed 2 Feb. 2023.*
- Пэрлээ Д./Х/. Монголын тамга зүйн асуудалд.
- Ганбаатар Ц., Дэлгэржаргал П. Чингис хаанаас Чан Чунь бомбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн зарлиг. Түүхийн судлал XXXVI боть. Уб., 2006, 52.
- Шагдар Х. Даидаваа Ч. Монголын эзэнт гүрний тухай Монголын орчин үеийн түүх бичлэг. Түүхийн судлал. XXXVIII боть, Уб., 2008, 117-118.
- Бира Ш. Монголын тэнгэрийн үзэл. Уб., 2011. 71.
- van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p118*
- Болдбаатар Ж. Монголын эзэнт гүрэн,үүсэл, цэцэглэлт, мөхөл. Түүхийн судлал. XXXV боть, Уб., 2004, 57.
- Жүгдэр Ч. Хүннүгийн түүх соёл. Уб., 2011. 134.
- Инжинаш В. Хөх судар. 1290-1291.
- Бор Ж. Монгол Улсыг хүрээлэн буй геополитик, геостратегийн гадаад орчин: өнгөлөн далдлалт, төөрөгдүүлэлт, бодит байдал хашлага давах боломж, Уб., 2022. 238.
- Сумъяабаатар. Б. Монголын Нууц Товчоон, Уб., 2020. 2221. Данж барих нь алба барих, барьцааны хүн илгээх гэсэн хоёр утгатай бөгөөд энд барьцааны хүн илгээх гэсэн утгаар орсон байгааг Б.Сумъяабаатар нотлон тайлбарласан байна.
- Igor de Rachewiltz, 'Some Reflections on Činggis Qan's jasy', *East Asian History* 6 (1993):100. (Based on Boyle's translation of the Persian version of the letter in P. Pelliot, 'Les Mongols et la papauté', *Revue de l'Orient chrétien* 23, no. 30 [1922-1923]: 15–16. The Persian quote is found on p. 15, ll. 9-10.) *On the Yasa in Chinese legal sources, see Paul Heng-chao Ch'en, Chinese Legal Tradition under the Mongols: The Code of 1291 as Reconstructed (Princeton: Princeton University Press, 1979), 4–10.*
- Morgan, 'Revisited', 303 cited in van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p122*
- Morgan, *The Mongols*, 98. See also Morgan, 'The "Great Yāsā of Chingiz Khān"', 164–66. cited in van den Bent, J. M. C. (2020). *Mongols in Mamluk eyes: Representing ethnic others in the medieval Middle East. [Thesis, fully internal, Universiteit van Amsterdam].p122*